



МАЙНИНГ ТЕХНОЛОГИ ЭНД ЭКУЙПМЕНТ ХХК-ИЙН
ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН НУТАГ
ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ
ТӨСЛИЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН
ТАЙЛАН



Улаанбаатар хот
2022 он

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	1
ЗУРГИЙН ЖАГСААЛТ.....	2
ОРШИЛ.....	3
БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	4
1.1 Төслийн ерөнхий мэдээлэл	4
1.1.1 Төслийн нэр:.....	4
1.1.2 Төсөл хэрэгжүүлэгч:	4
1.1.3 Төслийн байршил.....	4
1.1.4 Хүчин чадал	4
1.1.5 Ажиллах хүч	4
1.1.6 Барилга байгууламж	4
1.1.7 Дэд бүтэц.....	4
1.1.8 Хог хаягдал.....	4
1.2 Химийн бодисын агуулах.....	4
1.3 Химийн бодисын агуулахын үйл ажиллагаа	5
1.4 Хөдөлмөр аюулгүй ажиллагаа.....	7
БҮЛЭГ 2. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт.....	8
БҮЛЭГ 3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	10
3.1 Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний зорилт	10
3.2 Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	10
3.2.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	10
3.2.2 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт	15
3.2.3 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	15
3.2.4 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	15
3.2.5 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	16
3.2.6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	18
3.2.7 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	26
Дүгнэлт.....	29

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1-1. Химийн бодисын агуулахад хадгалагдах химийн бодисууд.....	6
Хүснэгт 2-1 Нөлөөллийн үнэлгээ	8
Хүснэгт 3-1. МТЭЭ ХХК-ын төслийн талбайн худгийн мэдээлэл.....	13
Хүснэгт 3-2. Агаарын чанарын хэмжилт хийсэн цэгийн байршил.....	19
Хүснэгт 3-3. Хэмжилт хийх үеийн цаг уурын үзүүлэлтүүд.....	20
Хүснэгт 3-4. PM2.5 болон PM10 тоосонцрын хэмжилтийн үр дүн.....	21
Хүснэгт 3-5. Дуу чимээний хэмжилтийн үр дүн	21
Хүснэгт 3-6. Усны чанарын хэмжилт хийсэн байршил, цэгүүд.....	21
Хүснэгт 3-7. Төслийн талбай дахь худгийн бичил амьсгалын үзүүлэлтүүдийн шинжилгээний дүн	23
Хүснэгт 3-8. Төслийн талбайн хөрсний зүсэлт хийгдсэн цэгүүд.....	24

Хүснэгт 3-9. Хөрсний химийн задлан шинжилгээний дүн.....	26
Хүснэгт 3-10. Хөрсний механик бүрэлдэхүүн.....	26
Хүснэгт 3-11. Төслийн талбайн хөрсөнд агуулагдах хүнд металлын хэмжээ	26

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1-1. Химийн бодисын агуулах.....	4
Зураг 1-2. Химийн бодис агуулах өрөө	5
Зураг 1-3. Химийн бодисын савлагаа, 1 тонн IBC	5
Зураг 1-4. Анхны тусламжийн өрөө.....	7
Зураг 1-5. Аюулгүй ажиллагааны хамгаалалтын хувцас.....	7
Зураг 3-1. Усалгаа хийдэг шороон зам ба усалгаа хийж буй үйл явц	10
Зураг 3-2. Замын усалгаа чийгшүүлэлтээр тоос дарах үйл явц.....	11
Зураг 3-3. Химийн бодис агуулах өрөө	11
Зураг 3-4. Химийн бодисын агуулахын Ажлын байрны нэгдсэн үзлэгийн хуудас ба агааржуулах төхөөрөмж.....	12
Зураг 3-5. Химийн бодисын агуулахад асгарлын иж бүрэн хэрэгсэл байршуулсан зураг.....	12
Зураг 3-6. “Spill smart” асгарлын иж бүрдлийн бүртгэлийн хуудас	13
Зураг 3-7. Анхааруулах тэмдэг байршуулсан тээврийн хэрэгслээр нийлүүлэлт хийж буй байдал. 13	
Зураг 3-8. Төслийн талбайд байрлах худаг (шар) болон бохир ус хадгалах сан (ногоон)	14
Зураг 3-9.Төслийн талбайд байгуулсан ногоон байгууламж	14
Зураг 3-10. Тээврийн хэрэгслийн үзлэг, хяналтын үйл явц	15
Зураг 3-11. Төслийн талбайд орчны тохижуулалт хийсэн байдал.....	15
Зураг 3-12. Төслийн талбайд байрлуулсан 3 тасалгаат, ангилан ялгах зориулалттай хогийн сав..	16
Зураг 3-13. Ахуйн хог хаягдлыг ачуулж буй байдал.....	16
Зураг 3-14. Анхны тусламжийн өрөө.....	17
Зураг 3-15. Аюулгүй ажиллагааны хамгаалалтын хувцас	17
Зураг 3-16. Анхны тусламжийн хэрэгслийн бүртгэл, нөхөн сэлбэсэн бүртгэл	17
Зураг 3-17. Төслийн талбайд галын аюулаас хамгаалах, сэргийлэх хэрэгслүүдийг байршуулсан зураг.....	18
Зураг 3-18. Агаарын чанарын хяналт шинжилгээ хийсэн байршил	19
Зураг 3-19. DustTrak 8520 загварын зөөврийн.....	20
Зураг 3-20. Усны мониторингийн цэгүүдийн байршил	22
Зураг 3-21. Усны хэмжилт, дээжлэлтийн явц (2022.08.15).....	22
Зураг 3-22 Хүдгийн гадна болон дотор талаас	
Зураг 3-23. Монгол орны хөрс-био уур амьсгал.....	23
Зураг 3-24. Төслийн талбайн ойр орчмын хөрсөн бүрхэвч.....	25
Зураг 3-25. Хөрсний зүсэлт хийсэн цэгүүд	25
Зураг 3-26. Шинэ ажилтныг ХАБЭА-н сургалтад хамруулсан сертификат	27
Зураг 3-27. Ажилтнуудаа эрүүл мэндийн урьдчилсан шинжилгээнд хамруулсан баримт.....	28
Зураг 3-28. Даланзадгад суманд мод тарьж буй байдал	30

ОРШИЛ

Майнинг Технологи Энд Экуйпмент ХХК нь 2008 онд гадаад худалдаа, аялал жуулчлалын чиглэлээр үүсгэн байгуулагдсан ба одоогоор химийн бодисын нийлүүлэлт болон үл эвдэх сорилтын туршилт, шинжилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Өмнөговь аймгийн Ханбогд сумын Жавхлант багийн нутаг дэвсгэрт Оюу Толгой уурхайн үйл ажиллагаанд ашиглагдах химийн бодисыг ханган нийлүүлэх мөн Өмнөговь аймаг дахь уул уурхайн компаниудад ижил төрлийн химийн бодис ханган нийлүүлдэг бусад байгууллагууд химийн бодисын тээвэрлэлтийн үедээ түр дамжин өнгөрөх, химийн бодисоо түр хадгалах зориулалтаар химийн бодисын агуулахыг барьж байгуулан 2016 оноос хойш Ханбогд суманд 10 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Майнинг Технологи Энд Экуйпмент ХХК-ийн “Химийн бодисын агуулах” төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсрууллаа. Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 өдрийн А/618 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам-ыг баримтлав.

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан нь үндсэн 3 бүлэг, оршил, дүгнэлт, хавсралт материал зэргээс бүрдэнэ. Уг тайланд 2022 онд Химийн бодисын агуулах төслийн үйл ажиллагааны хүрээнд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд авсан арга хэмжээг тусгав.

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

- | | | |
|-------|---------------------|--|
| 1.1.1 | Төслийн нэр: | “Майнинг Технологи Энд Экуйпмент” ХХК-ийн Химийн бодисын агуулах төсөл |
| 1.1.2 | Төсөл хэрэгжүүлэгч: | ✓ Улсын бүртгэлийн дугаар: 9011145057
✓ Регистрийн дугаар: 5213045 |
| 1.1.3 | Төслийн байршил | Өмнөговь аймгийн Ханбогд сумын Жавхлант багийн нутаг, Тэмээн ус нэртэй газарт байрлана |
| 1.1.4 | Хүчин чадал | 30 нэр төрлийн химийн бодисыг агуулах |
| 1.1.5 | Ажиллах хүч | Тус агуулах нь нийт 10 ажилтантай. Үүнд: Захирал - 1, Оффис менежер -1 Жолооч-1, харуул -1, нярав-1, нягтлан - 2, тогооч -1, Агуулахын ажилтан - 2 |
| 1.1.6 | Барилга байгууламж | Төслийн нийт талбай нь 0.5 га ба үндсэн байгууламжууд нь:
✓ Химийн бодисын агуулах – 1000 м ²
✓ Анхны тусламжийн өрөө – 30м ²
✓ Ачих буулгах тавцан - 350 м ²
✓ Бетонон зам – 60*20м байна. |
| 1.1.7 | Дэд бүтэц | Цахилгаан хангамж: Нарны эрчим хүч
Дулаан хангамж: Цахилгаан эрчим хүч
Ус хангамж: Өөрийн эзэмшлийн 1 худгаас |
| 1.1.8 | Хог хаягдал | Төслийн ажилчдын хэрэглээнээс хоногт 3 кг, жилд 1.08 тн хатуу хог хаягдал гардаг. Харин шингэн хог хаягдал хоногт 0.63 м ³ , жилд 35.28 м ³ гардаг. |

Тус агуулах нь Өмнөговь аймгийн Ханбогд суманд байрладаг. Аюулгүй ажиллагааны бараа бүтээгдэхүүн болон бусад химийн бодисыг технологийн дагуу хадгалдаг ба энэхүү үйл ажиллагаатай холбоотой татвар, хураамжийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, орон нутгийн иргэдийг ажлын байраар хангаж, Ханбогд сумын хөгжилд бодитой дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

1.2 ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ

Химийн бодисын агуулахын нийт хэмжээ нь 1000 м² талбайтай дөрвөн хэсэг агуулах, 350 м² бараа ачиж буулгах тавцан, 60*20 м бетонон зам, 30 м² талбай бүхий анхны тусламжийн өрөөг байгуулсан. Тус агуулахын барилгын суурийг цутгамал төмөр бетоноор цутгасан, барилгын хана 480 мм зузаантай ба MNS 0831:2001-ийн шаардлагыг хангасан 500 кг/м³ эзлэхүүн жинтэй 380 мм-ийн тоосго өрж гадна талаас 100 мм зузаан хөөсөн полистрол хавтангаар дулаалсан.



Зураг 1-1. Химийн бодисын агуулах

1.3 ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тус агуулах нь Өмнөговь аймаг дахь уурхайнуудад химийн бодис нийлүүлэгч байгууллагуудад зориулан химийн бодисыг түр хадгалах, дамжин өнгөрөөх агуулахын үйл ажиллагаа эрхэлдэг.

Одоогоор химийн бодисуудыг Оюу толгой ХХК-д нийлүүлдэг бөгөөд мөн агуулахын зарим хэсгийг бусад компанид түр хугацаагаар түрээслэн ашиглуулдаг. Оюу толгой ХХК өөрсдийн хэрэгцээ шаардлага болон улирлаас хамааран янз бүрийн хугацааны давтамжтайгаар өөрсдийн унаагаар ирж авдаг.

Химийн бодисуудыг Сүхбаатар, Замын-Үүд, Чингис хаан, Алтанбулаг боомтуудаар оруулж ирж байна. Эдгээр химийн урвалжуудыг БНХАУ-ын Чиндоа хотын компаниас гэрээний дагуу худалдан авч байгаа бөгөөд химийн бодисын хадгалалт тээвэрлэлтийг стандартын дагуу гүйцэтгэдэг.

Химийн бодисын агуулахад бодис бүрийн шинж чанарыг харгалзан өөр, өөр өрөөнд дээрх зурагт үзүүлсний дагуу эгнүүлэн хадгалдаг.



Зураг 1-2. Химийн бодис агуулах өрөө

Тус агуулах нь химийн бодис түр хадгалах дөрвөн тустай өрөө (Зураг 1-2) бүхий агуулахтай бөгөөд шингэн болон хатуу төлөвтэй бодисуудыг стандартын дагуу тус, тусад нь ангилан хадгалдаг. Агуулахад хадгалагдах химийн бодисуудын сав баглаа бодлын хувьд 1 төрлийн савлагаатай /IBC/ байна. Химийн бодисын савлагааг доорх зурагт үзүүлээ.



Зураг 1-3. Химийн бодисын савлагаа, 1 тонн IBC

Химийн бодисын сав баглаа боодлын хог гарсан тохиолдолд, хаягдлыг түр хугацаанд хадгалж байгаад Цэцүүх Трейд ХХК-д нийлүүлнэ. Агуулахад хадгалагддаг бодисуудын жагсаалтыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1-1. Химийн бодисын агуулахад хадгалагдах химийн бодисууд

Хүснэгт 1-1. Химийн бодисын агуулахад хадгалагдах химийн бодисууд

№	Олон улсын нэршил	Монгол нэр	Химийн томьёо	CAS дугаар	НҮБ-ийн дугаар	Агуулахад хадгалах бодисын хэмжээ /тн/		Нэг удаад агуулахад байх хэмжээ /тн/
						1 жилд	3 жилд	
1	AEROPHINE®3418A Promoter	АЕРОФИН®3418 цуглуулагч	$C_8H_{18}NaPS_2 + C_{12}H_{27}PS$	13360-78-6 3982-87-4	3261	900	2700	113
2	ANTIPREX®D	Акрилийн натри	$C_3H_3O_2NA$	7446-81-3	-	800	2400	100
3	WTS 5-0017	Цайрын хлорид Фосфорын хүчил Бусад аюулгүй хольц	$ZnCl_2-H_3PO_4$	7646-85-7 7664-38-2 Аюулгүй	3264	50	450	19
4	WTS 5-1125	Натрийн Толиприазол Бусад аюулгүй хольц	NaOH	64665-57-2 Аюулгүй	1719	50	150	20
5	Dowfroth 250-D	Dowfroth 250-D флотацийн хөөсрүүлэгч	$CH_4O(C_3H_6O)_n$	37286-64-9	-	5	15	1
6	HYPERFLOC® MG 653	Анионы төрлийн акриламидын		-	-	800	2400	100
7	MAGNAFLOC®5250 (AU)	Полиакриламид, анион		-	-	800	2400	104
8	MIBC F500	Фломин Ф 500 хөөсрүүлэгч	$(CH_3)_2CHCH_2CH(OH)CH_3$	108-11-2	2053	900	2700	113
9	WTS 7-106	Хлорын уусмал	$NaClO_2$	7758-19-2	1908	700	2100	60
10	Sodium Dodecyl Sulfate	Натрийн додецилсульфат	$CH_3(CH_2)_{11}SO_4Na$	68018-81-2		50	150	6
11	Chlorine Dioxide solution	Хлорын Давхар Ислийн Уусмал	ClO_2-HCl	7647-01-0 7732-18-5	-	50	150	6
12	WTS 9-33	Хлорт үстөрөгчийн уусмал	HCl	7647-01-0	1789	5	15	1
13	Magnafloc 338	Өтгөрүүлэгч урвалж	NH_2CONH_2	57-13-6	-	400	1200	50
14	3D TRASAR ® 3DT120	Хөргөлтийн ус цэвэрлэгч		-	-	5	15	1
15	3D TRASAR ® 3DT180	Зэврэлтээс хамгаалагч		-	-	5		1
16	OREPREP OTZ-100 FROTHER	Флотацийн урвалж	$C_8H_{16}O_2+CH_2=CHCHO$		3082	50	150	6
17	Ксантогенат PAX	Цуглуулагч урвалж	$C_6H_{11}KOS_2$		-	800	2400	100
18	Calcium chloride	Кальцийн хлорид	CaCl ₂	10043-52-4 Аюулгүй	-	300	900	100
19	Sodium Alpha Olefin	Натрийн тетрадекан сульфонат	$C_nH_{2n-1}SO_3Na(N=14-16)$	68439-57-6	-	50	150	20
20	Hydrochloric acid	Хлорт үстөрөгчийн уусмал	HCl	7647-01-0	-	50	150	10
21	Methanol	Метанол	CH ₃ OH	67-56-1	-	10	30	10
22	Isopropyl Ethylthiocarbamate	Цуглуулагч урвалж IPETC	$C_6H_{13}NOS$	141-98-0	-	300	900	50
23	Sulphide sodium	Хүхэрт натри	Na ₂ S	1313-82-2	-	1000	3000	125
24	Ethylene glycol	Этиленгликоль	$C_2H_6O_2$	107-21-1	-	200	600	63

25	Sodium tetraborate decahydrate	Бура	$\text{Na}_2[\text{B}_4\text{O}_5(\text{OH})_4] \cdot 8\text{H}_2\text{O}$	1303-96-4	-	10	30	38	
Шинээр нэмэгдэж буй химийн бодисууд									
26	Ammonium lignosulfonate	Аммонын лигносульфонат давс	-	8061-51-	-	100	300	50	
27	Calcium lignosulfonate	Кальцийн лигносульфонат давс	-	8061-51					
28	Sodium metabisulfite	Натрт метабисульфит	$\text{Na}_2\text{S}_2\text{O}_5$	7681 -57-4	-	100	300	50	
29	Calcium nitrite	Кальцийн нитрит	$\text{Ca}(\text{NO}_2)_2$	13780-06-8	-	130	390	10	
30	Calcium formate	Хөрс тогтворжуулагч ISS-1	-	7664-93-9 77-92-9 7664-38-2 104-55-2	3264	200	600	50	

1.4 ХӨДӨЛМӨР АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

Тухайн химийн бодисын агуулахын ажилчид химийн бодистой ажиллах техник технологи сайн эзэмшсэн, аливаа осол гэмтэлд өртөхгүйгээр хэвийн үйл ажиллагаагаа тасралтгүй ажиллах аюулгүй орчин, анхны тусламжийн өрөө (Зураг 1-4) болон таних тэмдэг тэмдэглэгээг байрлуулсан. Анхны тусламжийн өрөө нь ажилчдад эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх тоног төхөөрөмжөөр бүрэн тохижсон.



Зураг 1-4. Анхны тусламжийн өрөө

Тус компани нь агуулахын ажилчдад хагас жилийн нормтой иж бүрдэл ажлын хувцас, улирлын нормтой хамгаалах бүс, хамгаалалтын хэрэгсэл бээлий, маск зэргийг тогтмол олгодог.



Зураг 1-5. Аюулгүй ажиллагааны хамгаалалтын хувцас

Техник аюулгүй ажиллагааны болон үйл ажиллагааны зааварчилгааны талаар ажилчид зориулсан сургалт явуулдаг. Аваар ослын эрсдэлийг бууруулах үүднээс агуулахын талбай руу орох цэгүүдийг тодорхойлох, аюултай материал, бодис хадгалах зориулалтын агуулахыг бетонон гадаргуутай барих, талбайн ажилчдыг зохих сургаалтанд хамруулан аваарын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлж байна.

Барилгын дээврийн дотор талд гал унтраах зориулалттай автомат нунтаг гал унтраагуурыг (түнгүс) агуулахын дээрийн дотор талд гурван эгнээгээр байрлуулсан.

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Майнинг технологи энд экуйпмент ХХК-ийн Химийн бодисын агуулах төслийн БОННУ-ээр төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг дараах байдлаар тодорхойлсон байна.

Хүснэгт 2-1 Нөлөөллийн үнэлгээ

Байгаль орчны үзүүлэлтүүд	Нөлөөлөх байдал		Хугацаа		Чиглэл			Эрчим		
	Шууд	Шууд бус	Богино хугацааны	урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Өөрөө зохицуулагдах	Бага	Дунд	Хүчтэй
Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Гадаргын усны урсцын өөрчлөлт										
Гадаргын усны чанарын өөрчлөлт		x		x		x		x		
Ой, ургамлын бүтцийн өөрчлөлт	x			x			x	x		
Хөрсний элэгдэл, эвдрэл	x			x		x			x	
Геологийн тогтцын өөрчлөлт		x	x					x		
Зэрлэг амьтдын оронзайн өөрчлөлт	x			x				x		
Уур амьсгалын /бичил/ өөрчлөлт	x			x		x			x	
Байгалийн нөөц ашиглалт										
Газрын гадаргын нөөц баялаг	x			x		x		x		
Бэлчээр, тэжээлийн байдал	x			x			x	x		
Эрдэс түүхий эдийн нөөц /ус/		x		x			x	x		
Эрчим хүчний нөөц	x			x		x		x		
Байгаль, орчны өөрчлөлт										
Ундны усны чанар, хэмжээ	x			x		x		x		
Урсгал усны нөөцийн горим										
Агаарын бохирдол	x			x		x		x		
Хөрсний, бохирдол элэгдэл	x			x			x		x	
Хорт бодис хүн, амьтанд нөлөөлөх	x			x		x				x
Дуу чимээний нөлөөлөл	x			x				x		
Нийгэмд үзүүлэх нөлөөлөл										
Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	+			+		+		+		
Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх		+		+		+		+		
Хүн амын орлого өөрчлөгдөх	+			+		+		+		
Хүн амын эрүүл мэнд, соёл	+			+	+			+		
Эдийн засаг, нийгмийн асуудал										
Татварын орлого өөрчлөгдөх	+			+	+			+		
Орон нутгийн орлог өөрчлөгдөх	+			+		+		+		
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	+			+		+		+		
Ажлын байр нэмэгдэх	+			+		+		+		
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+		+					+		

Бусад нөлөөлөл										
Ахуйн бохир уснаас хөрс, газрын доорх ус бохирдох	x		x				x	x		
Химийн бодис асгарах, алдагдах	x			x	x				x	
Галын аюулгүй алдагдах	x		x		x					x
Дүн	23	4	4	23	4	14	5	21	6	2

Тайлбар: "x" сөрөг нөлөөлөл, "+" эерэг нөлөөлөл

Хүснэгтээс үзвэл байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөллийн нийт тоо 27 байна. Нөлөөллийн байдлыг доор үзүүлэв. Үүнд:

Шууд нөлөөлөл. Энд болзошгүй нөлөөллийн ихэнх нь шууд нөлөөлөлд хамрагдаж байна. Төслийн явцад тодорхой хэмжээгээр хөрсний эвдрэл гарах, үүний улмаас ургамлын бүтцийн өөрчлөлт гарч болзошгүйгээс гадна ундны усны чанар, хэмжээ болон агаарын чанарт бага зэргийн сөрөл нөлөө үзүүлэх талтай.

Шууд бус нөлөөлөл. Хүн болон техникийн хөдөлгөөн ихсэх, эзэмшил газрын гадаргын тогтоц өөрчлөгдөн хотгор гүдгэрийн сөрөг хэлбэрүүд үүсэх, хог хаягдлыг удаан хугацаагаар хадгалах болон автомашины төвлөрлөөс шалтгаалан агаар, хөрс бохирдох нөлөөлөл зэрэг нь шууд бус сөрөг нөлөөлөлд хамаарч байна.

Богино хугацааны нөлөөлөл. Үүнд зөвхөн төслийн үйл ажиллагаанаас болон барилга, байгууламж нэмж барих тохиолдолд өнгөн хөрсний бохирдол ба эвдрэл, агаарын бохирдол түр зуур гарах зэрэг нөлөөлөл хамаарна.

Урт хугацааны нөлөөлөл. Төслийн үйл ажиллагаа удаан хугацаагаар үргэлжлэх учир байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн ихэнх /85.2%/ нь урт хугацаанд экологийн тогтолцоонд бүгд буцалтгүй нөлөөлөхөөр байна. Үүнд үйл ажиллагааны улмаас орчны, гадаргын хэлбэр, ургамлын бүрхэц, бичил үүр амьсгал өөрчлөгдөх эрчим хүчний хэрэглээний өсөлт гарах, дуу чимээ нэмэгдэх зэрэг сөрөг нөлөөллүүдээс гадна, орон нутгийн эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөллүүд хамаарч байна.

Нөлөөллийн эрчим. Төслийн нийт нөлөөллийг эрчимшлээр нь авч үзвэл, 72.4% нь сул болон сулавтар, 20.7% нь дунд зэрэг, 6.9% нь их зэрэгт багтах нөлөөлөл байна. Нийт нөлөөллийн 17 нь сөрөг байхаар байна.

БҮЛЭГ 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

3.1 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ

Майнинг технологи энд экуйпмент ХХК-ийн Химийн бодисын агуулах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах үүрэгтэй.

Төсөл хэрэгжүүлэгч болох Майнинг технологи энд экуйпмент ХХК нь 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу ажиллан төлөвлөгөөнд тусгагдсан бүх ажлыг амжилттай хэрэгжүүлэн ажилласан.

3.2 БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль хамгаалах төлөвлөгөөнд төслийн үйл ажиллагаанаас гол болон болзошгүй сөрөг нөлөөлд өртөх орчноор буюу агаарын чанар, хөрс болон ургамлан нөмрөг, газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зэрэг чиглэлүүдээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн биелэлтийг харуулав.

3.2.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

3.2.1.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Тоос дарах

Химийн бодисын агуулахад сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмжид заасныг үндэслэн засмал замаас, төслийн талбай хүртэл үргэлжлэх 500 м шороон замын усалгааг хийх төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. Уг зам усалгааны ажил нь дулааны улиралд, салхи ихтэй өдрүүдэд 7 хоног 1-2 удаа тогтмол хийгддэг.



Зураг 3-1. Усалгаа хийдэг шороон зам ба усалгаа хийж буй үйл явц



Зураг 3-2. Замын усалгаа чийгшүүлэлтээр тоос дарах үйл явц

Химийн бодисын хадгалалтын аюулгүй байдал

Майнинг технологи энд экүйпмент ХХК-ийн Химийн бодисын агуулах нь MNS 6458:2014 стандартад нийцэн бөгөөд химийн бодисуудын хадгалалтын нөхцөлөөс шалтгаалан аюулгүй байдлын үүднээс 4 ангилан хадгалж байна.



Зураг 3-3. Химийн бодис агуулах өрөө

Химийн бодисын агуулахын агааржуулах төхөөрөмжийн үзлэг оношилгоо

Химийн бодисын агуулахад сард нэг удаа ажлын байрны нэгдсэн үзлэг тогтмол хийгддэг. Уг үзлэг оношилгоогоор агааржуулах төхөөрөмжийн хэвийн ажиллагааг шалгаж шаардлагатай тохиолдолд засвар үйлчилгээ хийгддэг. 2022 оны байдлаар ямар нэгэн гэмтэл гарч засвар үйлчилгээ хийгдээгүй байна.

Ажлын байрны нэгдсэн үзлэгийг Майнинг технологи энд экүйпмент ХХК-ийн захирлын 19/02 тушаалаар батлагдсан Маягт №03 дагуу явуулдаг байна. Уг үзлэгийг агуулахын ажилтан ба химич болон буюд агуулахын ажилтнуудын хамт явуулдаг.

Доорх зурагт Химийн бодисын агуулахын Ажлын байрны нэгдсэн үзлэгийн хяналтын хуудас болон химийн бодисын агуулахад суурилуулсан агааржуулагчийн зургийг харууллаа.

МТӨЕ **Ажлын байрны нэгдсэн үзлэг**
 Компанийн хяналтын 19/02 тушаалаар батлагдсан маягт № 03
 Компанийн хяналтын 19/02 тушаалаар батлагдсан маягт № 03

Ажлын байрны нэгдсэн үзлэгийн саяа нэг удаа ажлын бүтэцтэй ажлаар

Ажлын байрны нэгдсэн үзлэгийн ажлын байрны шавь эрүүс ажлыг боловд аюулгүй ажиллагааны үнэнийг зөргөөр мөрөөдөж, засан засан залруулах арга хэмжээг анх, цаашин дараахдаа хийж гэрээг ижилдэглэж байх зэрэгт анхааралтай ажил хэрэгээр хийж, дутагдал танилцаж болгохтой.

Үзлэгийн байдал 2 хүний бүрэлдүүлэгтэй хийж ба хоологдох шаардлагатай "ЭАААБЮ-ны бэлдэг ба журам"-ын 9.8 "Тайлбар" хэсэгт үзлэгийн явдал хийхэд анхааралтай гэмтэлдэнэ. Шаардлагатай бол маягтын арын хуудсанд хоологдох фото зургийг хавсаргана. Асуулаа бүрт тийм – Ү эсвэл үгүй – Х гэсэн тэмдэглэлгээ тавьж хариуцана байна.

Угас хэийг ажиллагааны нэр, албан тушаал: *Э.Нарансүх, Э.Ариунболор, Ч.Гунд, С.Тогтоолбог*

Огноо/Цаг: *2022.10.05*

Ажлын талбай / Байршил: Химийн бодисын агуулах

Бүрэлдүүлэгч	Шалгах агуулагууд	Тайлбар	Тийм	Үгүй
А. Ерөнхий Эрүүд Мэргээн Агуулах / Цаг Агаарын Норманд Байдал	Дараах үйлдэл зөв амжилдаж байна уу ?			
	1. Агааржуулагчийн систем		✓	
	2. Угас мэдрэх систем		✓	
В. Нөвтрөх орох ба Гаргах	3. Гэрэлтүүлэг		✓	
	4. Ажлын үүрэгтэй хэсгийн гэрэлтүүлэг орох гаргах гэрлээр аюулгүй нөвтрөх боломжтой		✓	
	5. Гэгээний агуулах үед хурдан аюулгүй гаргах гарч байна уу		✓	
	6. Барилга байгууламжда засвар үйлчилгээтэй хийхэд нөвтрөх орох аюулгүй орч байна уу		✓	
С. ХХХ болон Анхны Тусламж	7. Бүх ажигчид тухайн орчинд тогтсон ХХХ хэрэглээг эсэх		✓	
	8. Намууд ХХХ-г өмж, шууд хэрэглэх боломжтой жиж, жиж хэрэглээгээ мэддэг эсэх		✓	
	9. Ажлын тусламжийн хайрныг зөв байршилд байна уу		✓	

Ажлын байрны Аюулгүй Ажиллагааны Туслах Маягт Хуудас 1. нийт 6



Зураг 3-4. Химийн бодисын агуулахын Ажлын байрны нэгдсэн үзлэгийн хуудас ба агааржуулах төхөөрөмж

3.2.1.2 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт


Химийн бодисын асгарлаас сэргийлэх арга хэмжээ

Майнинг технологи энд экуйпмент ХХК-ийн төслийн талбайд асгарал болсон тохиолдолд шууд хөрсөн бүрхэвчийг бохирдуулах сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор төслийн талбайг үе шаттайгаар хатуу хучилттай болгох ажлыг гүйцэтгэв. Бүрэн хатуу хучилттай болгосон төслийн талбайн фотог Зураг 3-8-аас харна уу.

Түүнчлэн химийн бодисын 4 тусгаар агуулах тус бүрд "Spill Smart" асгарлын хэрэгслийн иж бүрдэл, галын аюулгүй байдлын самбар, бүртгэл хяналтын хуудаснуудыг байрлуулсан байна. Асгарлын иж бүрэн хэрэгсэл байршуулсан зургийг харуулав.



Зураг 3-5. Химийн бодисын агуулахад асгарлын иж бүрэн хэрэгсэл байршуулсан зураг



Зураг 3-6. "Spill smart" асгарлын иж бүрдлийн бүртгэлийн хуудас

Тээврийн машины аюулгүйн тэмдэглэгээ

Майнинг технологи энд экуйпмент ХХК-ийн Химийн бодисын агуулахаас нийлүүлэлт хийж буй тээврийн хэрэгслүүдэд химийн хортой аюултай бодисын анхааруулах тэмдэг тэмдэглэгээг MNS 5029:2011 стандартын дагуу авто тээврийн хэрэгслийн 2 хажуу тал болон ар талд байршуулж тээвэрлэлт хийдэг байна.



Зураг 3-7. Анхааруулах тэмдэг байршуулсан тээврийн хэрэгслээр нийлүүлэлт хийж буй байдал

3.2.1.3 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Худаг

Майнинг технологи энд экуйпмент ХХК-ийн Химийн бодисын агуулахын төслийн талбайд Гео инженеринг групп ХХК-аар худаг гаргуулсан байна. Уг худаг нь унд ахуй, үйлдвэрлэлийн зориулалттай бөгөөд усны чанарын хяналт шинжилгээний ажлыг явуулж байна.

Энэхүү худгийн мэдээллийг Хүснэгт 3-1-т, худгийн байршлыг Зураг 3-8-т харуулав.

Хүснэгт 3-1. МТЭЭ ХХК-ын төслийн талбайн худгийн мэдээлэл

№	МТЭЭ ХХК-ын төслийн талбайн худгийн мэдээлэл		
1	Байршил	Өргөрөг	43° 05' 4579"
		Уртраг	106° 90' 4803"
2	Ус ашиглалтын дүгнэлт гаргуулсан огноо	2021 оны 03 сарын 01 өдөр	
3	Худгийн паспорт авсан огноо	2021 он 02 01 өдөр	
4	Худгийн зориулалт	Унд ахуй, үйлдвэрлэл	
5	Худгийн ундарга	0.9 л/с	

Түүнчлэн усан орчинд ахуйн шингэн хаягдлаас шалтгаалан газрын доорх усыг бохирдуулахаас сэргийлж үл нэвчих материалаар хийгдсэн шингэн хаягдал хадгалах санг MNS 5924:2015 стандартын дагуу суурилуулсан.




Зураг 3-8. Төслийн талбайд байрлах худаг (шар) болон бохир ус хадгалах сан (ногоон)

3.2.1.1 Ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Тээврийн хэрэгслийн эвдрэл, доголдлын нөлөөгөөр ургамлан бүрхэвчид сөрөг нөлөө үзүүлэхээс урьдчилан сэргийлэх, зайлс хийх зорилгоор тээврийн хэрэгслүүдэд хөдөлгөөнд оролцох болгонд тогтмол үзлэг хийж байна. Доорх зургуудад 2022 оны 11 сарын 28, 12 сарын 03 өдрүүдэд тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдалд хяналт шалгалт хийсэн үзлэгийн хуудас болон үзлэгийн үйл явцыг харуулав.

2022 онд явуулсан техникийн үзлэгүүдээр машин механизмудад бага хэмжээний эвдрэл гэмтэл гардаг боловч дор бүр нь засварлан ямар нэг эвдрэл гэмтэлгүй болгон хөдөлгөөнд оролцуулдаг байна.



Зураг 3-9. Төслийн талбайд байгуулсан ногоон байгууламж



Зураг 3-10. Тээврийн хэрэгслийн үзлэг, хяналтын үйл явц

3.2.1 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Химийн бодисын агуулахын төслийн талбай орчимд аливаа түүх, соёлын өв, дурсгалт олдвор тэмдэглэгдээгүй бөгөөд аливаа газар шорооны ажлын үед олдвор олдвол Соёлын өвийг хамгаалах хуулийн дагуу арга хэмжээ авах, олдворыг гэмтээхгүйгээр үйл ажиллагааг түр зогсоох шаардлагатай.

3.2.2 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Ахуйн хог хаягдал хадгалах, тээвэрлэх

Химийн бодисын агуулахад хог хаягдлыг ангилан ялгаж хаях зорилгоор ус үл нэвтрэх дотортой материалаар хийгдсэн 3 тасалгаат хог хаягдлын цэгийг байрлуулсан ба хог хаягдлыг ангилан ялгаж хэвшээд байна.

Түүнчлэн цугларсан ахуйн хог хаягдлыг төслийн талбайтай зэрэгцээ байрлах аж ахуй нэгж болох Говь Газ ХХК-ийн Ханбогд сумын хот тохижилт үйлчилгээний газартай байгуулсан гэрээн дор сард 2 удаа төлөвлөгөөний дагуу тээвэрлүүлж зориулалтын газар хаяж байна. Говь Газ ХХК-ийн Хог хаягдлын гэрээг тайланд хавсаргав.



Зураг 3-12. Төслийн талбайд байрлуулсан 3 тасалгаат, ангилан ялгах зориулалттай хогийн сав



Зураг 3-13. Ахуйн хог хаягдлыг ачуулж буй байдал

Аюултай хог хаягдал

Майнинг технологи энд экуйпмент ХХК-ийн Химийн бодисын агуулах төсөл нь химийн аюултай, хортой бодисыг үйл ажиллагаандаа ашиглахгүй бөгөөд химийн бодисыг зөвхөн дамжин өнгөрүүлэх зориулалтаар ашиглах тул энэ төрлийн хаягдлууд үйл ажиллагааны явцад гарахгүй боловч химийн бодисын сав баглаа боодол задрах, ашиглалтын шаардлага хангахгүй болсон тохиолдолд химийн бодисын болон химийн бодис агуулсан сав баглаа боодлын хаягдал гарах магадлалтай юм. Иймд бэлэн байдлыг хангаж Цэцүүх Трейд ХХК-тай аюултай хог хаягдлыг хүлээн авахаар гэрээ байгуулсан. Уг гэрээг энэхүү тайланд хавсаргав.

Түүнчлэн 2022 онд Химийн бодисын агуулахын үйл ажиллагааны явцад гарсан химийн бодис хадгалж байсан сав болон шуудайг гэрээний дагуу Цэцүүх Трейд ХХК-д өгч устгуулсан. (баримтыг хавсаргав)

3.2.3 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Химийн бодисын агуулахын төслийн талбайд анхны тусламжийн өрөө болон таних тэмдэг тэмдэглэгээг байрлуулсан. Анхны тусламжийн өрөө нь ажилчдад эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх тоног төхөөрөмжөөр бүрэн тохижсон



Зураг 3-14. Анхны тусламжийн өрөө

Тус компани нь агуулахын ажилчдад хагас жилийн нормтой иж бүрдэл ажлын хувцас, улирлын нормтой хамгаалах бүс, хамгаалалтын хэрэгсэл бээлий, маск зэргийг тогтмол олгодог.



Зураг 3-15. Аюулгүй ажиллагааны хамгаалалтын хувцас

Түүнчлэн анхны тусламжийн хэрэгслүүдийг тогтмол шалган бүртгэж, хугацаа нь дууссан бүтээгдэхүүнийг нөхөн сэлбэж байна.




Байрвал - Компанийн агуулахын анхны тусламжийн өрөө

АНХНЫ ТУСЛАМЖИЙН ХЭРЭГСЭЛ ХАМГААЛАХ МАТЕРИАЛЫН БҮРТГЭЛ

№	Хайрмалттай байгаа материалын нэр	Заруулалт	Хэрэглэх хугацаа	Дээрх хэргийг эзнийг шалгах өдөр			Дээрх хэргийг хайрмалттай материалыг шалгах өдөр			Хайрмалттай байгаа материалын нэр
				Байр	Огноо	Хэрэглэгч	Огноо	Хэрэглэгч	Огноо	
1	Hot cold рас /мас/	Хайрмалттай үед хэрэглэх	Хүйтэн жинт галтж хамгаан тусгаж авахын тулд хэрэглэнэ. Гялалт галтж хамгаан тусгаж авахын тулд хэрэглэнэ.	1 байр						
2	Hotand ice рас /мас/	Хайрмалттай үед хэрэглэх	Хүйтэн жинт галтж хамгаан тусгаж авахын тулд хэрэглэнэ.	1 байр			11.01			
3	Хамгаалах хувцас /Хамгаалах хувцас/	Хайрмалттай үед хэрэглэх	Хүйтэн жинт галтж хамгаан тусгаж авахын тулд хэрэглэнэ.	1 байр			11.01			
4	Хамгаалах хувцас /Хамгаалах хувцас/	Хайрмалттай үед хэрэглэх	Хүйтэн жинт галтж хамгаан тусгаж авахын тулд хэрэглэнэ.	1 байр			11.01			
5	Хамгаалах хувцас /Хамгаалах хувцас/	Хайрмалттай үед хэрэглэх	Хүйтэн жинт галтж хамгаан тусгаж авахын тулд хэрэглэнэ.	1 байр			11.01			
6	Хамгаалах хувцас /Хамгаалах хувцас/	Хайрмалттай үед хэрэглэх	Хүйтэн жинт галтж хамгаан тусгаж авахын тулд хэрэглэнэ.	1 байр			11.01			
7	Хамгаалах хувцас /Хамгаалах хувцас/	Хайрмалттай үед хэрэглэх	Хүйтэн жинт галтж хамгаан тусгаж авахын тулд хэрэглэнэ.	1 байр			11.01			
8	Хамгаалах хувцас /Хамгаалах хувцас/	Хайрмалттай үед хэрэглэх	Хүйтэн жинт галтж хамгаан тусгаж авахын тулд хэрэглэнэ.	1 байр			11.01			
9	Хамгаалах хувцас /Хамгаалах хувцас/	Хайрмалттай үед хэрэглэх	Хүйтэн жинт галтж хамгаан тусгаж авахын тулд хэрэглэнэ.	1 байр			11.01			
10	Хамгаалах хувцас /Хамгаалах хувцас/	Хайрмалттай үед хэрэглэх	Хүйтэн жинт галтж хамгаан тусгаж авахын тулд хэрэглэнэ.	1 байр			11.01			
11	Хамгаалах хувцас /Хамгаалах хувцас/	Хайрмалттай үед хэрэглэх	Хүйтэн жинт галтж хамгаан тусгаж авахын тулд хэрэглэнэ.	1 байр			11.01			
12	Хамгаалах хувцас /Хамгаалах хувцас/	Хайрмалттай үед хэрэглэх	Хүйтэн жинт галтж хамгаан тусгаж авахын тулд хэрэглэнэ.	1 байр			11.01			

Зураг 3-16. Анхны тусламжийн хэрэгслийн бүртгэл, нөхөн сэлбэсэн бүртгэл

Барилгын дээврийн дотор талд гал унтраах зориулалттай автомат нунтаг гал унтраагуурыг (тунгус) агуулахын дээрийн дотор талд гурван эгнээгээр байрлуулсан. Галын хоруудыг улиралд нэг удаа шалган тэмдэглэл хөтөлдөг ба дууссан, шаардлага хангахгүй галын хор байгаа тохиолдолд сольж нөхөн сэлбэлт хийдэг. Гал хамгаалах хэрэгслүүдийг байршуулсан зургийг доор харуулав.



Зураг 3-17. Төслийн талбайд галын аюулаас хамгаалах, сэргийлэх хэрэгслүүдийг байршуулсан зураг

3.2.4 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

3.2.2.1 Агаарын чанар

Өмнийн Говийн хуурай агаар, улирлын хүчтэй салхи шуурга болон цөлийн сул хөрс нь агаарт тоосжилт үүсэх гол эх үүсвэр болдог. Агаар дахь тоосжилтын хэмжээ ихэссэнээр ус агуулагч хурдас болон ургамалжилтад нөлөөлөхийн зэрэгцээ хүн амын тав тухтай байдал болон эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг. Ялангуяа $10 \mu\text{g}/\text{m}^3$ –оос бага хэмжээтэй нарийн тоосонцроос /PM10/ хүний эрүүл мэндэд эрсдэл учирдаг. 2.5-аас $10 \mu\text{g}/\text{m}^3$ хүртэлх хэмжээтэй нарийн тоосонцрыг амьсгалснаар хүний мөгөөрсөн хоолойд гэмтэл учруулж уушгины бронхит үүсгэдэг. $2.5 \mu\text{g}/\text{m}^3$ -с бага хэмжээтэй нарийн тоосонцор нь хүний уушгинд үлдсэнээр амьсгалах эрхтэнг гэмтээдэг. NO₂, SO₂ and CO зэрэг бодисын агаар дахь хэмжээ ихэссэнээр хүний эрүүл мэнд доройтож, эрсдэлд ордог. Дотоод шаталтат тоног төхөөрөмжүүд (уурын зуух, цахилгаан станц) болон хүнд оврын тээврийн хэрэгслүүд зэрэг эх үүсвэрээс мөн эдгээр хорт бодис агаарт ялгардаг.

Төслийн нөлөөллийн бүс дэх шороон замаар тээврийн хэрэгсэл их хэмжээгээр зорчих явдал болон төслийн эхэн үеийн барилгын ажлууд зэргээс 1- ээс 100 хүртэлх микрон хэмжээтэй нарийн ширхэгт тоосонцор үүсдэг. Төслийн бүтээн байгуулалтаас тоосжилт их хэмжээгээр үсэх ба үүнд зөвхөн авто зам төдийгүй ил уурхай, хаягдал чулуулгийн овоолго, талхлагдсан талбай болон хаягдал хадгалах байгууламж зэрэг мөн түлхэц үзүүлдэг. Төслийн талбайн хөрсний хэв шинж болон хуурай цаг уурын нөхцөл байдал зэргээс үүдэн хөндөгдсөн хөрснөөс агаарт дэгдэх тоосжилт үлэмж хэмжээгээр нэмэгдэж байна.

Оюу Толгой орчмын агаарын чанарын суурь нөхцөлийн судалгааг 2002 оны 7 дугаар сард “Эко-Трейд” ХХК анх явуулсан байна. Энэ судалгаагаар тоос, SO₂, NO₂ зэрэг үзү хэмжиж, төсөл хэрэгжих талбайн 7 цэгээс дээж авч тодорхойлсон. Шинжилгээний дүнгээс үзвэл SO₂ болон NO₂-ын агуулга нь Монгол Улсын агаарын чанарын стандартад заасан агаарын бохирдлын ЗДХ-нээс доогуур байна. Харин тоосжилтын түвшин нэлээд өндөр ялангуяа замын орчим болон хайгуулын ангийн орчимд эвдэгдсэн газар, өрөмдлөг хийж байгаа газруудад нэлээд өндөр байгааг тогтоосон. Түүнчлэн 2004, 2006, 2007 онуудад “ОС МТ” ХХК тоосны мониторингийн суурь судалгаа хийсэн байна. Эдгээр цэг дээр “ОС МТ” ХХК-ий тодорхойлсон тоосны агууламжийн хэмжилтийн дүн болон бусад мэдээлэл Оюу Толгой ХХК-д байгаа тул энэхүү тайланд давтаж оруулсангүй. Харин тоосны агууламжтай холбоотой зарим гол үзүүлэлтүүдийг дор үзүүллээ. Тухайлбал, “ОСМТ” ХХК-ий хийсэн хэмжилтийн дүнгээр зарим өдөр тоосны агууламж зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давж (0.234 мг/м³) байсан нь тухайн нутаг дэвсгэрт тохиолддог шороон шуургатай холбоотой гэж тэмдэглэжээ.

Мөн Оюу Толгойн орчим салхины хурд 12 м/сек-ээс их болох үед тоос босч, агууламж нь 1.0 м өндөрт зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давдаг байдал ажиглагдаж байсан байна. Оюу Толгойн ойролцоо орших Ханбогд сумын цаг уурын станцын 1975- 2005 оны 30 жилийн мэдээгээр төслийн нутаг дэвсгэрт явган болон шороон шуургатай байх хугацаа 3-5 дугаар сард дунджаар 15-25 цаг байна.

Судалгааны арга зүй

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт байрлах төслийн агаарын чанарын хэмжилтийг 2021 оны 8 сарын 27-ны өдөр хяналтын 1 цэгт хийж гүйцэтгэсэн. Хэмжилт хийсэн цэгүүдийн газарзүйн солбицлыг Хүснэгт 3-2-т, байршлын зураглалыг Зураг 3-18-т харуулав.

Хүснэгт 3-2. Агаарын чанарын хэмжилт хийсэн цэгийн байршил

Цэгийн дугаар	Координат		Байршил
1	N 43° 03' 19.6"	E 106° 54' 16.1"	Төслийн талбай дотор

Зураг 3-18. Агаарын ча



нарын хяналт шинжилгээ хийсэн байршил

2021 оны 8 сарын 27-ны өдрүүдийн агаарт агуулагдах тоосонцрын хэмжилтийг хийхдээ тухайн үеийн цаг уурын үзүүлэлтүүдийг хэмжсэн. Тоосонцрын хэмжилтийг хийх явцад салхины дундаж

хурд 2.0-2.4 м/с, температур 26.9°C-28.8°C байсан бол дундаж чийгшил 24.4%-тай байсан. Цаг уурын хэмжилтийн үзүүлэлтүүдийг Хүснэгт 3-3-т харуулав.

Хүснэгт 3-3. Хэмжилт хийх үеийн цаг уурын үзүүлэлтүүд

#	Үзүүлэлт	8 сарын 27 - 14:00	8 сарын 27 - 16:00
1	Салхины хурд	2.0 м/с	2.4 м/с
2	Чийг	24.1 %	24.7 %
3	Агаарын температур	28.8°C	26.9°C

Алдааны хязгаар: 1-20 л/мин мужид + 5%, 0.2-1 л/мин мужид + 7% байна.

Том ширхэглэгт болон нарийн ширхэглэгт тоосонцор: Төслийн талбай орчим дахь агаарт агуулагдах PM2.5 болон PM10 тоосонцрын агууламжийг DustTrak 8520 зөөврийн багажийн тусламжтайгаар тодорхойлсон (Зураг 3-19).

Dusttrack 8520 загварын багаж нь зайгаар ажилладаг лазер фотометр юм. Энэхүү багажаар PM 2.5 эсвэл PM10 хэмжээтэй тоосонцрын агууламжийг хэмждэг. Тус зөөврийн багаж нь 0.002-100 мг/м³ хүрээг хамран агууламжийг мг/м³ нэгжээр харуулдаг.



Зураг 3-19. DustTrak 8520 загварын зөөврийн

Дуу чимээ: Шуугианы хэмжилтийг “MNS 5003:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугиан хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага.” стандарт аргачлалын дагуу EXTECH Noise Dosimeter, Datalogger, and Sound Level Meter SL355) загварын зөөврийн багажаар хийж гүйцэтгэсэн.



Фото зураг 3-1. EXTECH Noise Dosimeter, Datalogger, and Sound Level Meter SL355 загварын зөөврийн багаж

Судалгааны үр дүн

Агаарын чанарын судалгааны үр дүнг 2021 оны 8 сарын 27 өдөр хийсэн PM_{2.5}, PM₁₀ тоосонцор, дуу чимээ хэмжилтийн үр дүнд тулгуурлан боловсруулав.

Тоосонцрын хэмжилтийн үр дүн: Талбайгаас авсан том ширхэгт болон нарийн ширхэгт тоосонцрын 2 удаагийн хэмжилтийн үр дүнг MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандартын 24 цагийн дундаж хүлцэх агууламжтай харьцуулахад хүлцэх агууламжаас дунджаар 3-4 дахин бага үзүүлэлттэй байна. Хэмжилтийн үеийн үйл явцыг Фото-зураг 3-1-т болон

үр дүнг Хүснэгт 3-4-т харуулав.



Фото-зураг 3-1. Агаарын чанарын хэмжилтийн үйл явц

Агаар дах тоосонцрын хэмжилтийн дүнгээс үзэхэд MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандартын хүлцэх агууламжаас давсан тохиолдол илрээгүй байна.

Хүснэгт 3-4. PM_{2.5} болон PM₁₀ тоосонцрын хэмжилтийн үр дүн

#	Хэмжилт	PM _{2.5}	PM ₁₀
		мкг/м ³	
1	8 сар-27 өдөр 14:00 цагт	14	35
2	8 сар-27 өдөр 16:00 цагт	11	40
Дунджаар		12.5	37.5
MNS 4585:2016 зөвшөөрөгдөх дээд хэмжээ		50	100

Дуу чимээний хэмжилтийн дүн: Төслийн талбайд 2 удаагийн хэмжилтээр авсан дуу чимээний үзүүлэлт нь Монгол улсад мөрдөгддөг “MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандартын хүлцэх агууламж 60дБ(А) байдгаас бага зэргийн хэтэрсэн үзүүлэлтгүй байна.

Хүснэгт 3-5. Дуу чимээний хэмжилтийн үр дүн

#	Хэмжилт	Дуу чимээ (дБА)
1	8 сар-27 өдөр 14:00 цагт	48.0
2	8 сар-27 өдөр 16:00 цагт	53.4
MNS 4585:2016 (дБА, 16 цагийн дундаж)		60

3.2.3.1 Усны чанар

Майнинг технологи энд экуйпмент ХХК-ийн Химийн бодисын агуулах төслийн талбайд өөрийн эзэмшлийн нэг худаг байрлана. Уг худаг нь унд ахуй, үйлдвэрлэлийн зориулалттай. Энэхүү хэсгийг төслийн талбайд байрлах нэг худгаас авсан шинжилгээний хариунд тулгуурлан боловсруулав.

Судалгааны арга зүй

Усны дээжийг 2021 оны 10 сарын 21-ний өдөр төслийн унд ахуйн худгаас авав. Хэмжилт хийсэн цэгүүдийн газарзүйн солбицлыг Хүснэгт 3-6-т, байршлын зураглалыг Зураг 3-20-т харуулав.

Хүснэгт 3-6. Усны чанарын хэмжилт хийсэн байршил, цэгүүд

Цэгийн дугаар	Координат	Байршил
1	N 43° 03' 16.6"	E 106° 54' 17.7"
		Унд ахуйн худаг




Зураг 3-20. Усны мониторингийн цэгүүдийн байршил

Төслийн талбай дахь худгаас усны дээж авахдаа Монгол улсын “MNS ISO 5667:2000 Гүний уснаас дээж авах зөвлөмж стандарт”-ыг мөрдлөг болгон ажилласан. Усны дээжийг 24 цагийн дотор лабораторид хүргүүлсэн. Ундны усны дээжид Бичил амьсудлалын үзүүлэлтүүдийг шинжлүүлсэн бөгөөд Ханлаб ХХК-н магадлан итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэв. Шинжилгээний үр дүнг Монгол улсад мөрдөгддөг “MNS 900:2018 Ундны усны эрүүл ахуйн шаардлага түүнд тавих хяналт” стандартын шаардлагатай харьцуулсан.

Дээжлэх болон шинжилгээ хийх хүртэлх хугацаанд явагдаж болох физик, хими, биологийн процессын дүнд усны найрлага өөрчлөгдөхөөс урьдчилан сэргийлэх дараах арга хэмжээг авсан:

Усны дээжийг авах: Дээж авахдаа он сар өдөр, төрөл, гадаад байдал, байршил координатыг тэмдэглэж авав. Усны дээжийг зориулалтын аргаар ариутгасан 1 литрийн багтаамжтай хуванцар саванд авсан. Усны дээжийн савыг нэрмэл усаар зайлж ариутгасан. Энэхүү хуванцар сав нь их концентрацитай бодис бүхий дээж хадгалаагүй худалдааны цэвэршүүлсэн цэвэр усны хуванцар сав юм. Усны дээж авахдаа савыг дүүргэн авч саванд агаар байх зайгүйгээр тагласан. Энэ нь тээвэрлэлтийн үед сэгсрэгдэх, хийнүүдийн хоорондох харилцан үйлчлэлийг хязгаарлах ач холбогдолтой.



Зураг 3-21. Усны хэмжилт, дээжлэлтийн явц (2022.08.09)

Усны дээжийн хадгалалт, тээвэрлэлт: Усны дээж бүхий савуудыг сайтар таглаж, дээжлэх үеийн

мэдээллийг тэмдэглэн, гэрэл болон хэт халууны нөлөөнөөс хамгаалах үүднээс сүүдэр газар хадгалсан. Тээвэрлэлтийн явцад дээжийг асгарч, муудахаас болгоомжлон дээж бүхий савыг цаасан хайрцагт хийж, сайтар битүүмжилсэн.

Усан сангийн усны эх үүсвэрт эрүүл ахуйн болон энгийн хамгаалалтын бүс бий болгох зорилгоор худгийн гадуур байшин барьсан ба тоолуурын баталгаажилт хийлгэж усны тоолуурын заалтаар усны нөөц ашигласаны төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж байна.



Зураг 3-22. Худаг гадна болон дотор талаас

Судалгааны үр дүн

Шинжилгээний үр дүнг Монгол улсад мөрдөгддөг “MNS 0900:2018 Ундны усны эрүүл ахуйн шаардлага түүнд тавих хяналт” стандартын шаардлагатай харьцуулсан. Шинжилгээний үр дүнг дэлгэрэнгүй тусгав.

Үр дүнгээс харвал төслийн талбай дахь ундны зориулалттай худгийн бичил амь судлалын үзүүлэлтүүд нь MNS 0900:2018 стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээний утгаас хэтрээгүй байна.


Хүснэгт 3-7. Төслийн талбай дахь худгийн бичил амь судлалын үзүүлэлтүүдийн шинжилгээний дүн

№	Үзүүлэлт	Нэгж	ЗДХ MNS 0900:2018	Үр дүн
1	Бактерийн ерөнхий тоо	1 мл-д	100	5
2	Халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нянгийн тоо	100 мл-д	Илрэхгүй	Илрээгүй
3	Колиформ гэдэсний бүлгийн нянгийн тоо	100 мл-д	Илрэхгүй	Илрээгүй
4	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян	25 мл-д	Илрэхгүй	Илрээгүй
5	<i>Clostridium perfringens</i>	100 мл-д	Илрэхгүй	Илрээгүй

3.2.3.2 Хөрсөн бүрхэвч

“Майнинг Технологи Энд Экүйпмент” ХХК-н Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших химийн бодисын агуулах төслийн талбайн хөрсний төлөв байдлыг тодорхойлох зорилготой хээрийн судалгааны ажлыг хийж лабораторийн шинжилгээний үр дүнгүүд болон тухайн орчны өмнөх судлагдсан байдлын мэдээ материал зэргийг нэгтгэн дүн шинжилгээ хийж тайланг боловсруулав. Мөн төслийн талбайн хөрсөн бүрхэвчийн тархалтын зураг болон хөрсний эвдрэлийн зургийг хөрсний суурь зураг (Монгол орны хөрсний 1:500000-ын зураг, 2013), Landsat, Google Earth зэрэг мэдээнд тулгуурлан ArcGIS 10.3.1 программ дээр хийж гүйцэтгэсэн.

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт Монгол орны хөрс-био уур амьсгалын зураглалаар Цөлөрхөг хээрийн бор, Цөлийн саарал хөрс болон Давсархаг хөрс тархсан байна (Зураг 3-22).



Зураг 3-23. Монгол орны хөрс-био уур амьсгал

Судалгааны арга зүй

Хээрийн судалгаа: Тус төслийн талбайн гадаргын төлөв, хөрсний хэв шинж, хөрсний хучилт, хөрсний бохирдол, хүнд металл зэргийг тодорхойлохоор 2021 оны 08 сарын 27 өдөр 1 цэгийг сонгон авч хөрсний бичиглэл хийн дээж авч мөн фото зургаар баримтжуулав (Хүснэгт 3-8).

Хүснэгт 3-8. Төслийн талбайн хөрсний зүсэлт хийгдсэн цэгүүд

№	Зүсэлтийн дугаар	Дээж авсан газар	Уртраг	Өргөрөг
1	Зүсэлт-1	Химийн бодисын агуулах орчим /ард/	Е 106° 54' 16.3''	Н 43° 03' 19.9''

Лабораторийн задлан шинжилгээ: Төслийн талбайгаас авсан хөрсний дээжийг “Эс Жи Эс Монголиа” ХХК-н хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд оруулж хөрсөн дэх хүнд металл, хими, физик шинж чанарын ерөнхий үзүүлэлтүүдийг тодорхойлсон. Хөрсний химийн задлан шинжилгээг доорх аргаар тодорхойлсон. Үүнд:


Тодорхойлох бодисын нэр	Хэмжилт хийсэн арга	Аргазүйн нарийвчлал
Ялзмаг	И.В. Тюрин	<0,04 мг/100 г хөрс
Нийт азот	Кьельдал	<0,04 мг/100 г хөрс
Хөрсний урвалын орчин	РН-метр	<0,2
Хөдөлгөөнт фосфор	Мачигин	<0,05 мг/100 г хөрс
Солилцох кали	Мачигин	<0,05 мг/100 г хөрс
Хөрсний шингээх цогц	Трилон.Б.	<0,2%
Карбонат	Кальци метрийн	<0.5%
Механик бүрэлдэхүүн	Аэрометрийн	<0,5%

Төсөл хэрэгжих орчны хөрсөн бүрхэвч, түүний онцлог

Тус төслийн талбай орчим нь говийн бор хөрс, цөлийн бор саарал хөрсний бүст хамрагдана. Төслийн талбайд үндсэндээ сул хөгжилтэй, говийн сийрэг тархсан (бүрхэц 8-25%) ургамлан нөмрөгийн дор бүрэлдэн тогтсон хөрс зонхилно. Хөрсөн дэх органик бодисын агууламж нь 1.0%-аас бага, сул шүлтлэг, шүлтлэг чанар нь кальци, магнийн катионуудын агууламжаас хамаарч, хөрсний давхарга бүрд харилцан адилгүй байна. Цөлийн бор саарал хөрс бүрэлдэх явц нь бусад төрлийн хөрснүүдээс ялгаатай байдаг. Учир нь говийн хуурай цаг уур болон ховор тохиолдох хур тунадас зэргээс шалтгаалж, хөрсний 80% нь эрдэсэжсэн байдаг. Хөрсний шинж чанар нь натрийн карбонат, бусад хэлбэрийн карбонат, уусан давс, шохойлогтой эсэхээс хамаарч тодорхойлогдоно. Судлаачид говийн хөрс тогтворжиход хөрсний чийгийн горим их нөлөө үзүүлнэ гэж үздэг. Түүний нөлөөгөөр хөрсний өнгөн хэсэг дээр карбонат, бикарбонат хуримтлагдаж, давс агуулсан нимгэн шаварлаг үе бий болдог.

Говийн хөрс нь өвлийн цагт өнгөн хэсэгтээ 1-1.5 м гүнд хүртэл хөлдөнө. Улирлаас хамааран жилд 6-7 сарын турш урт удаан хугацаанд хөлдөнө. Дулааны улиралд бороо чийг ихтэй үед хөрсөн дэх биологийн идэвх ихээхэн дээшилдэг. Давсны өндөр агууламж, органик бодисын бага агууламж, хөрсний шүлтлэг чанар нь хөрсийг салхи, усны элэгдэлд амархан өртөх болон хурдан тархахад хүргэдэг. Энэ нь тухайн нутаг дэвсгэр элэгдэл, эвдрэлд өртөхөд голлох нөлөө үзүүлэх хүчин зүйл болно. Бороо ороход борооны ус 20-25 см гүн хөрсөнд нэвчих ба нэвчилт ихтэй газрууддаа 25 см-ээс ч илүү гүнд нэвчдэг. Борооны дараах газрын гүнд нэвчсэн чийг нь тухайн нутаг дэвсгэрийн ургамлан бүрхэвчийн ургах нөхцөлийг хангахад чухал үүрэгтэй байдаг.

Хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Химийн бодис агуулах” үйлчилгээ үзүүлэх төслийн 0.5 га талбайд тал газар, хөндий хотгорын хөрсний бүлэг тархсан байна (Зураг 2- 23).



Зураг 3-24. Төслийн талбайн ойр орчмын хөрсөн бүрхэвч

Төслийн талбайн хөрсний төлөв байдлын судалгаа, үр дүн

Хөрсний гадаргын төлөв байдал, хөрсний үе давхаргын морфологи шинж чанар, эвдрэл, хүнд металлын бохирдлын төлөв байдлыг тодруулах зорилгоор тодорхойлох зорилготой 1 цэгийг сонгон авч зүсэлт хийж дээж авсан (Зураг 3-24).



Зураг 3-25. Хөрсний зүсэлт хийсэн цэгүүд

Хөрсний хими, физик шинж чанар: Төслийн талбайд хийгдсэн хөрсний үндсэн зүсэлтийн үр дүн болон хөрсний дээжийн шинжилгээний үр дүнг Хүснэгт 3-9, Хүснэгт 3-10-т харуулав. Хөрсний химийн задлан шинжилгээний дүнгээс харахад хөрсний үржил шимийн үзүүлэлт болох ялзмагийн хэмжээ 1.142% буюу хөрсний үржил шимийн түвшин бага байна. Мөн карбонатын хэмжээ / CaCO_3 / 1.82% буюу бага байгаа бол урвалын орчин шүлтлэг буюу дунджаар 8.27 байна.

Түүнчлэн хөрсний цахилгаан дамжуулах чадвар (ЕС) нь тухайн хөрсөнд агуулагдах давсны хэмжээг илэрхийлнэ. Шинжилгээний дүнгээр Цахилгаан дамжуулах чадварын хэмжээ 0.181 dS/м байгаа нь давсны хэмжээ бага байгааг харуулж байна. Түүнчлэн ургамал ургахад тэжээлийн үүрэг

гүйцэтгэдэг фосфорын хэмжээ 100 гр хөрсөнд 1.27 мг/г байна. Өөр нэг чухал тэжээлийн үзүүлэлт болох хөдөлгөөнт калийн хэмжээ 18.3 мг/г байна.

Хүснэгт 3-9. Хөрсний химийн задлан шинжилгээний дүн

Дээжийн нэр	Координат	pH	CaCO ₃ %	Ялзмаг, %	EC _{2.5} , dS/m	Хөдөлгөөнт, мг/100гр	
						P ₂ O ₅	K ₂ O
“МТЭЭ” агуулахын ард	N 43° 03' 19.9" E 106° 54' 16.3"	8.27	1.82	1.147	0.33	3.4	18

Хөрсний дээжийг ширхгийн бүрэлдэхүүнээр элс, тоос, шаврын харьцаагаар тодорхойлоход элсэн фракцын хэмжээ 67.3%, тоосон фракцын хэмжээ 22.0%, шавар фракцын хэмжээ 10.8%-ийн хооронд тус тус хэлбэлзэж байна. Эдгээр ширхгийн бүрэлдэхүүний үзүүлэлтээр хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлоход элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй хөрс давамгайлсан тохиолдсон байна.

Хүснэгт 3-10. Хөрсний механик бүрэлдэхүүн

Дээжийн нэр	Координат	Ширхгийн хэмжээ, % (мм-ээр)		
		Элс (2-0.05 мм)	Тоос (0.05-0.002 мм)	Шавар (<0.002 мм)
“МТЭЭ” агуулахын ард	N 43° 03' 19.9" E 106° 54' 16.3"	67.3	22.0	10.8

Хөрс өн дэх хүнд металлын шинжилгээ: Төслийн талбайгаас хөрсний зүсэлт болон дээжийг хөрсний бохирдол, элэгдэл эвдрэл үүссэн байх магадлал бүхий цэг орчмоос авч хөрсний дээжид агуулагдах хүнд металлуудын агууламжийг Хүснэгт 3-11-т харуулав. Судалгааны үр дүнг МУ-ын “MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” стандартад заасан хөрсний органик биш (хүнд металл) бохирдуулагч бодисуудын зөвшөөрөгдөх дээд хэмжээтэй харьцуулав. Хөрсний дээжид нийт 33 төрлийн элементийн агууламжийг лабораторид тодорхойлсноос “MNS 5850:2019 Хөрсний чанар, Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” стандарттай харьцуулах боломжтой 12 элементийг сонгож авсан.

Хүснэгт 3-11. Төслийн талбайн хөрсөнд агуулагдах хүнд металлын хэмжээ

Дээжийн дугаар	Элемент, мг/кг											
	Pb	Cd	As	Cr	Sn	Sr	V	Cu	Ni	Co	Zn	Mo
Зүсэлт-1	15	<1.0	18	31	<10	277	86	23.4	14	6	66	<1
MNS 5850:2019	100	3	20	150	50	800	150	100	150	50	300	5

Төслийн талбайгаас авсан хөрсний дээжийн үр дүнгээс үзэхэд хөрсөнд агуулагдах хүнд металл, хөрс бохирдуулагч бодисын хэмжээ “MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” стандартаас давсан үзүүлэлт илрээгүй байна.

3.2.4 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт



ХАБЭА сургалт зохион байгуулах

ХАБ-ын мэдээлэл олгох, зааварчилгаа өгөх, сэргээх сургалтыг шинээр ажилтан авах бүрд дотоод нөөц бололцоог ашиглан техник аюулгүй ажиллагаа, үйл ажиллагааны нарийвчилсан зааварчилгааны сургалтыг явуулдаг. Аваар ослын эрсдэлийг бууруулах үүднээс агуулахын талбай руу орох цэгүүдийг тодорхойлох, аюултай материал, бодис хадгалах зориулалтын агуулахыг бетонон гадаргуутай барих, талбайн ажилчдыг зохих сургалтанд хамруулан аваарын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлж байна.

Зураг 3-26. Шинэ ажилтныг ХАБЭА-н сургалтад хамруулсан сертификат

Түүнчлэн, Оюу Толгой төслөөс зохион байгуулдаг хөдөлмөрийн эрүүл ахуйн сургалт, химийн бодистой харьцдаг ХАБЭА-н сургаалтад ажилтнуудаа үе шаттайгаар хамруулж байна

Галын аюулгүй байдлын дүгнэлт

Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт нь барилга байгууламжид гал унтраах тоног төхөөрөмж /гал унтраах автомат болон дохиоллын систем, утаа зайлуулах систем, усан ханамж/, анхан шатны багаж хэрэгсэл, бодис материал зэргийг байрлуулан ашиглахад зориулж үг дүгнэлтийг олгодог байна.

Майнинг технологи энд экуйпмент ХХК-ийн Химийн бодисын агуулах төслийн байгууламжийн Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт нь ийн хүчинтэй хугацааг 2021.08.27-2024.08.27 өдрийг хүртэл сунгуулсан байна. Шинэчилсэн Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлтийг түс тайланд хавсаргав.

Ажилчдын эрүүл мэнд

Бонавита болон СОС Монголиа эмнэлгүүдтэй гэрээ байгуулан жил бүр ажилтнуудаа эрүүл мэндийн нарийвчилсан үзлэгт хамруулдаг

SOS MEDICA MONGOLIA
UB INTERNATIONAL CLINIC

СОС Медика Монголиа УБ Интернэйшнал Эмнэлэг
Ажлын Урьдчилсан Сэргийлэх Үзлэг, Жилийн эрүүл мэндийн үзлэг

Замнадагч: **МАЙНИНГ ТЕХНОЛОГИ ЭНД ЭКУЙПМЕНТ ХХК**
Танивцуулагч

Улаанбаатар хот дахь СОС Медика Монголиа эмнэлэг нь Монголын амьдралын хэв маяг, орчин нөхцөлд тохируулан ажигд орхын өмнөх эмнэлгийн үзлэгийг санал болгож байна. Энэхүү үзлэг, шинжилгээнүүд нь тухайн ажилтан нь ажлыг мөргөж, ажлын орчиндоо эрүү мэндийн хувьд тэнцэх эсэхийг тодорхойлж өгөх зорилготой юм. Ажилтны ажил үүргийн хуваарийг хохюулах болох уу үзлэг, шинжилгээнүүд нь цашилд гарч болох өмнөхөөс урьдчилан сэргийлэх, мөн компанид учирч болох хохирол, урт хугацааны дараах эрсдийг бууруулах ач холбогдолтой.

Үзлэгийн дараах ОЮУ ТОЛГОЙ ХХК – ийн мэдээлэл дүүгү гүйцэтгэнэ:

- OT-10-B7-FRM-007-M Contractor Health Assessment Questionnaire
- OT-10-B7-FRM-0011-E Fitness Recommendation Report
- OT-10-B7-FRM-0008-E Audiometric Questionnaire
- OT-10-B7-FRM-0009-E Functional Capacity Assessment
- OT-10-B7-FRM-0018-E Respiratory Questionnaire

Үзлэгийн тоо: 250,000 /нэг хүний/
Дараах мэдээт шинжилгээг хүсэгчдэр хийлгэж болно (нэмэлт болон давтан шинжилгээ нь СОС Медика Монголиа эмнэлгийн ерөнхий стандарт үзлэг тооцогдоно)

- ДОХ-ын шинжилгээ ба шинжилгээний өмнөх зөвлөгөө (Эсрэг үзүүлэлттэй харуу гарсан тохиолдолд бид хуулийн дагуу эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэх ёстойг анхаарна уу)
- Спирт болон манууруулах бодис илгүүрэх шинжилгээ

© SOS MEDICA MONGOLIA CLINIC 2021

АЖИЛД ТОХИРОХ ТАЛААРХИ ЗӨВЛӨМЖ ТАЙЛАН

Үзлэг хийсэн эмч бэлгэнэ.

1. АЖИЛТНЫ ХҮВИЙН МЭДЭЭЛЭЛ		е. Иргэний харьяалал	
а. Осол	г. Үргэлжлэх ажиллагаа	г. Ажил олгогч/компани	д. Халтас
б. Нэр	д. Төрсөн өнөө	г. Халтас	д. Албан тушаал
в. Үзлэг хийсэн өдөр	д. Хүйс	г. Халтас	д. Албан тушаал

2. ҮЗЛЭГИЙН НАРИЙВЧЛАЛ

а. Үзлэгийн төрөл:	б. Үзлэгийн төрөл:	в. Үзлэгийн төрөл:	г. Үзлэгийн төрөл:
Ажилд оролын өмнө	Хугацаа	Ажилд буцах өрөө	Гарам
<input checked="" type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

3. АЖИЛД ТОХИРОХ ТАЛААРХИ ЗӨВЛӨМЖ – Дээрх ажилтны эрүүл мэндийн мэдээлэл, үзлэг хийж үзэж ажилтны эрүүл мэндийн байдал үндэсрэн дараах зөвлөмж өгөж байна.

<input checked="" type="checkbox"/>	1. Ажилд тохирой	Ажилтан нь тухайн ажилд болон байршилд тохиромж бус байгаагүй.
<input type="checkbox"/>	2. Давтан үзлэг, шинжилгээг шаардлагагүйгээр ажилд тохирой	Ажилтан нь тухайн ажилд болон байршилд тохиромж бус байгаагүй. Гэвчээ тогтоосон туршилтад эрүүл мэндийн зөвлөмжийг дагаж мөрдөж байгаа эсэхийг хянаж шалгахгүй.
<input type="checkbox"/>	3. Хүчтэрийн/уугаартай төрөл	Ажилтан нь үү ажилд эсвэл тогтоосон өмнөх байршилд тохиромж бус байгаагүй. Ажилд тохиромжтой OT-ийн мэдээлэл багасч үргэлжлэх ажилд тохиромжтой. Ажилд тохиромжтой OT-ийн мэдээлэл багасч үргэлжлэх ажилд тохиромжтой. Ажилд тохиромжтой OT-ийн мэдээлэл багасч үргэлжлэх ажилд тохиромжтой.
<input type="checkbox"/>	4. Ажилд тохиромжгүй, дагалдан үзлэг шинжилгээ шаардлагатай	Ажилтан нь үү ажилд эсвэл тогтоосон өмнөх байршилд тохиромж бус байгаагүй. Ажилд тохиромжтой OT-ийн мэдээлэл багасч үргэлжлэх ажилд тохиромжтой. Ажилд тохиромжтой OT-ийн мэдээлэл багасч үргэлжлэх ажилд тохиромжтой.
<input type="checkbox"/>	5. Ажилд тохиромжгүй	Ажилтан нь үү ажилд эсвэл тогтоосон өмнөх байршилд тохиромж бус байгаагүй. Ажилд тохиромжтой OT-ийн мэдээлэл багасч үргэлжлэх ажилд тохиромжтой. Ажилд тохиромжтой OT-ийн мэдээлэл багасч үргэлжлэх ажилд тохиромжтой.

4. Хэргээршилт /Нэмэлт санал эсвэл зөвлөмжүүд байгаа бол тусгаарлан утг.

Үзлэг хийсэн эмч: *Dr. P. P. P.* Огноо: *2024-08-28*

Хөдөлмөрийн эрүүл мэндийн зөвлөх эмч: *Dr. A. A. A.* Огноо: *2024-08-28*

Ажилд тохиромжгүй/галарх зөвлөмж нь үзлэг хийсэнээс хойш эхэлж *10* сар дучин төгсгөлд байна.

(Зөвхөн OT болон Кат-1 үзлэгийн гэрээт ажилтнуудад)

Хянагч: OT Health Hub Хөдөлмөрийн эрүүл мэндийн эмч. Огноо: *2024-08-28*

Гарын үсэг: *Dr. A. A. A.* Огноо: *2024-08-28*

RioTinto OT-10-B7-FRM-0011-E Хуудас 1-ийн 1

Зураг 3-27. Ажилтнуудаа эрүүл мэндийн урьдчилсан шинжилгээнд хамруулсан баримт

ДҮГНЭЛТ

Майнинг технологи энд экуйпмент ХХК-ийн Химийн бодисын агуулах төсөл нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байрлана. Тус агуулах нь Өмнөговь аймаг дахь уурхайнуудад химийн бодис нийлүүлэгч байгууллагуудад зориулан химийн бодисыг түр хадгалах, дамжин өнгөрөөх агуулахын үйл ажиллагаа эрхэлдэг.

Химийн бодисын агуулах нь 2022 оны БОМТ-ний Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Эдгээрт:

- ✓ Засмал замаас төслийн талбай хүртэлт 500 м үргэлжлэх шороон замд тээвэр хийх үед шороо тоос босож, агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлж дулааны улиралд, мөн салхины хурд өндөр байх үеүдэд замын усалгаа чийгшүүлэлтийг тогтмол хийж байна.
- ✓ Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээнд зөвлөсний дагуу тээврийн хэрэгслүүдэд үзлэг оношилгоо хийх дотоод журмын дагуу үзлэг хийж, хяналтын хуудсыг бөглөсөн байна.
- ✓ Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах зорилгоор химийн бодисын асгарлаас сэргийлэх асгарлын иж бүрдэл байрлуулж, төслийн талбайд ирж буй тээврийн хэрэгслүүдэд MNS 5029:2011 стандартын дагуу авто тээврийн хэрэгслийн 2 хажуу тал болон ар талд байршуулж тээвэрлэлт хийдэг байна.
- ✓ Хог хаягдлыг ангилан ялгах зориулалтаар 3 тасалгаат хогийг цэгийг байрлуулсан ба хогийг тогтсон хугацаанд Ханбогд сумын тохижилт үйлчилгээний газраар тээвэрлүүлж байна.
- ✓ Усан орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс сэргийлэх зорилготойгоор бууруулахаар химийн бодисын агуулахын төслийн талбайд ахуйн шингэн хаягдлын сан хоёрыг байгуулсан байна.
- ✓ Усан сан буюу худгийн гадуур байшин барьсан ба тоолуурын баталгаажилт хийлгэж усны тоолуурын заалтаар усны нөөц ашигласаны төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж байна.
- ✓ Химийн бодисын агуулах төсөл нь нийт 0.5 га талбайтай. Төслийн талбайд чацарганын мод, улиас, шар хуайс зэрэг 4 төрлийн тариалсан моддыг тордож ургуулах үйл ажиллагааг 2022 онд хэрэгжүүлсэн байна.
- ✓ Анхны тусламжийн хэрэгслүүдийг тогтмол шалган бүртгэж, хугацаа нь дууссан бүтээгдэхүүнийг нөхөн сэлбэж байна.
- ✓ Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд агаарт агуулагдах тоосны хэмжээ (2022.08.15), ахуйн үс хангамжийн худгийн дээжинд бичил амь судлалын үзүүлэлтүүд (2021.10.21) болон хөрсөн бүрхэвчийн ерөнхий болон хүнд металлын агууламж зэргийг шинжлүүлсэн байна.

БОМТ - ний 2021 оны биелэлтийг дүгнэсэн ажлын хэсгийн зөвлөмжийн дагуу дараах ажлуудыг хэрэгжүүлж гүйцэтгэсэн байна. Үүнд:

2022 оны 10 сарын 14- ны өдөр Даланзадгад суманд болсон Өмнөговь аймгийн БОАЖГазар болон Ойн ангиас зохион байгуулсан намрын мод тарих өдөрлөгт компанийн ажилтнууд оролцож мод тарив.




Зураг 3-28. Даланзадгад суманд мод тарьж буй байдал

2. ✓ Усны эх үүсвэрт эрүүл ахуйн болон энгийн хамгаалалтын бүс байгуулах зорилгоор усан сан буюу худгийн гадуур байшин барьсан ба 2022 онд Ус ашиглах гэрээ, болон эрхийн бичгийн хугацааг сунгаж усны тоолуурын заалтын дагуу усны нөөц ашигласаны төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж байна. (шинэчилсэн гэрээ, усны эрхзүйн бичгийг хавсаргав)
3. Түгээмэл тархацтай ашигт малтмалыг тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээс худалдан авах, хууль бус үйл ажиллагаа явуулж буй иргэн, хуулийн этгээдтэй ямар нэг гэрээ байгуулаагүй худалдан авалт хийгээгүй болно.
4. Тус зөвлөмжийн 4-р заалтын дагуу манай компани нь Өмнөговь аймаг болон Ханбогд сумын ЗДТГазар, сургууль гэх мэт олон нийтийн зүгээс зохион байгуулж буй спортын өдөрлөг, тэмцээн гэх мэт аливаа үйл ажиллагаанд санхүүгийн зүгээс дэмжлэг үзүүлэх хамтран зохион байгуулах зэргээр оролцож ирсэн ба цаашид ч аймаг, сумын ЗДТГазар, Байгаль орчны газраас зохион байгуулж буй Байгаль орчныг хамгаалах тэмдэглэлт өдрүүдийн аливаа арга хэмжээнд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллахад бэлэн байна.



БАТЛАВ.
"ЦЭЦҮҮХ ТРЕЙД" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

...../Н.БИЛГҮҮН/



БАТЛАВ.
"МАЙНИНГ ТЕХНОЛОГИ ЭНД
ЭКУЙПМЭНТ" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

...../Д.ТУЯА/

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

2022 оны 01 сарын 15-ны өдөр

№ Ш-22/013
Ү- 001224

Улаанбаатар хот

Нэг талаас Цэцүүх трейд ХХК /цаашид "Хүлээн авагч" гэх/ төлөөлж Үйлдвэрийн дарга албан тушаалтай Б.Дарамбазар, Нөгөө талаас Майнинг Технологи Энд Экуйпмент ХХК -г /цаашид "Үүсгэгч" гэх/ төлөөлж Оффис менежер албан тушаалтай Ц.Оюунчимэг бид харилцан тохиролцож Монгол улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль Засгийн газрын 2018 оны 116-р тогтоолын 1, 2-р хавсралт болох "Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам", Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал болон Байгаль орчны аюулгүй байдалтай холбогдох хууль, журмыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний агуулга

- 1.1. Энэхүү гэрээгээр Аюултай хог хаягдал үүсгэгчээс аюултай хог хаягдлын дагалдах бичгийн дагуу түүнээс гарч байгаа аюултай хог хаягдлыг хүлээн авагч нь хүлээн авч хадгалах, дахин боловсруулах, устгалд оруулах, үүсгэгч нь хүлээн авагчид тохиролцсон үнийг төлөх болон талуудын эдлэх эрх, үүрэг хариуцлагын талаар зохицуулна.
- 1.2. Эл гэрээгээр шууд зохицуулагдаагүй бусад харилцааг Монгол улсын Хог хаягдлын тухай хууль, Иргэний хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулна.
- 1.3. Аюултай хог хаягдлын тоо хэмжээ, төрөл болон үнийн талаар гэрээний Хавсралт 1-т тусгах ба талууд гэрээний хугацаанд аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртээ дагалдах бичгийг гэрээнд хавсаргах ба энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.

Хоёр. Аюултай хог хаягдалд тавигдах шаардлага

- 2.1. Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж "Аюултай хог хаягдал" гэсэн тэмдэглэгээтэй байна.
- 2.2. Аюултай хог хаягдал савласан сав бүр нь ямар химийн бодис хадгалж байсан тухай нэр шошготой байна.
- 2.3. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртээ үүссэн болон хуримтлагдсан хог хаягдлын хэмжээний талаарх бүртгэлийг хүлээн авагчид шилжүүлнэ.
- 2.4. Аюултай хог хаягдлыг шилжүүлэхдээ **БОАЖЯ Сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаалын 1-р хавсралтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг** бүрдүүлж өгнө.
- 2.5. Аюултай хог хаягдлын савыг суллаж онц хортой, тэсрэмтгий, шатамхай бодис /тухайлбал цианид натри гэх мэт/ -г тухайн бодисын шинж чанарт тохирсон уусмалаар цэвэрлэсэн байна. Хоосон сав нь ЗГ-н 2018 оны 116-р тогтоолын 1-р хавсралтын 5.7-5.9-д заасан шаардлагыг хангасан байвал зохино.

Хуудсыг баталгаажуулсан:

Хуудас 1/9


2.6. Үүсгэгч Аюултай хог хаягдлыг “Аюултай хог хаягдал” тээвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий Аж ахуй нэгжийн тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлүүлж хүлээн авагчид шилжүүлнэ.

Гурав. Аюултай хог хаягдлыг шилжүүлэх хугацаа, төлбөр төлөх нөхцөл

- 3.1. Гэрээний үргэлжлэх хугацаа нь 2022 оны 01 сарын 15 өдрөөс 2023 оны 01 сарын 14 өдрийг хүртэл 1 /нэг/ жилийн хугацаатай байна.
- 3.2. Эхний нийлүүлэлт нь гэрээ байгуулагдсанаас хойш 10 хоногийн дотор үүсгэгч нь хүлээн авагчид шилжүүлсэн байна.
- 3.3. Энэхүү гэрээний №1-д хавсралтад заасан Үүсгэгчээс гарах хаягдлын урьдчилсан төлөвлөгөөний дагуу аюултай хог хаягдалын хуримтлал үүссэн тохиолдолд үүссэн хаягдлын хэмжээнээс хамаарч 90-ээс 180 хоногт аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлсэн байна.
- 3.4. Үүсгэгч нь аюултай хог хаягдлаа шилжүүлэх тухай хүсэлтээ хүлээн авагчид албан бичгээр эсвэл info@tsetsuuh.mn хаягаар 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ. Хүлээн авагч тал үүсгэгч болон тээвэрлэгчтэй харилцан тохиролцож хүлээн авагчийн байранд аюултай хог хаягдал хүргэх хугацааг товлонго.
- 3.5. Хүлээн авагч нь үүсгэгчээс аюултай хог хаягдал шилжин ирэх товлосон өдөр, цагт аюултай хог хаягдлыг хүлээн авах хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.
- 3.6. Үүсгэгчийн шилжүүлэх аюултай хог хаягдлын хэмжээ, тоо ширхгийг гэрээний хавсралт №2-д заасан төлбөр тооцооны тарифын дагуу харгалзуулан тооцож тухайн үед шилжүүлэх аюултай хог хаягдлын төлбөрийн хэмжээ гарна.
- 3.7. Аюултай хог хаягдлыг хүлээн авагч хүлээн авах үед үүсгэгчээс ирүүлсэн дагалдах бичигт дурдсан мэдээлэл зөрсөнөөс үүдэж гэрээний үнэ өөрчлөгдөж болно. Энэ тохиолдолд хог хаягдлыг хүлээн авах үед тооцож гаргасан үнээр бодож үүсгэгч хүлээн авагчид төлбөрийг төлнө.
- 3.8. Үүсгэгч нь гэрээний төлбөрийг аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлэх тухай захиалга өгснөөс хойш ажлын 3 хоногийн дотор Цэцүүх трейд ХХК-ийн **Голомт банкны 1715132986** тоот дансанд төлбөрийн нэхэмжлэхийн дагуу 100 хувь төлнө.
- 3.9. Үүсгэгч нь хүлээн авагчийн тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр аюултай хог хаягдлыг тээвэрлүүлж, хүргэлтийн цэг дээр хүргүүлж болно. Хүлээн авагчийн тээврийн хэрэгслээр хог хаягдал ачиж, тээвэрлүүлэх тохиолдолд тусад нь аюултай хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулан, гэрээний дагуу зохих төлбөрийг төлнө.

Дөрөв. Талуудын эрх, үүрэг

- 4.1 Үүсгэгчийн эрх, үүрэг:
 - 4.1.1 Үүсгэсэн аюултай хог хаягдлаа гэрээнд заасан хугацааны дотор хүлээн авахыг хүлээн авагчаас шаардах эрхтэй.
 - 4.1.2 Үүсгэгч нь гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангасан аюултай хог хаягдлыг хүлээн авагчид хүлээлгэн өгнө.
 - 4.1.3 Үүсгэгч нь Аюултай хог хаягдлын дагалдах бичгийг 4 хувь үйлдэж, гарын үсэг тамга тэмдэг дарж өөртөө 1 хувь, тээвэрлэгчид 1 хувь, хүлээн авагчид 2 хувийг илгээж, хүлээн авагчаас хүлээн авсан гарын үсэг, тамга тэмдэг дарагдсан 1 хувь дагалдах бичгийг буцаан авна.
 - 4.1.4 Аюултай хог хаягдлыг хүлээн авагчид хүргэх тээврийн зардлыг хариуцна.




Хуудсыг баталгаажуулсан: _____

- 4.1.5 Үүсгэгч Аюултай хог хаягдлыг хүлээн авагчаар тээвэрлүүлэхээр бол тусад нь аюултай хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулна.
- 4.1.6 Гэрээгээр тохиролцсон төлбөрийг хүлээн авагчид хугацаанд нь төлнө.
- 4.1.7 Шилжүүлэх аюултай хог хаягдлын талаарх мэдээллийг хүлээн авагчид үнэн зөв мэдээлнэ. Худал, буруу ташаа мэдээлснээс бусдын эрүүл мэнд, амь нас, талуудын эд хөрөнгө болон байгаль орчинд хохирол учирвал үүнээс үүсэх хохирлыг үүсгэгч тал хариуцна.
- 4.1.8 Үүсгэсэн аюултай хог хаягдлаа хүлээн авагчид шилжүүлэх тухайгаа 5-аас доошгүй хоногийн өмнө хүлээн авагчид мэдэгдэнэ.
- 4.2 Хүлээн авагчийн эрх, үүрэг
- 4.2.1 Үүсгэгчээс Гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангасан аюултай хог хаягдлыг хүлээн авах эрхтэй.
- 4.2.2 Үүсгэгчээс шилжүүлсэн аюултай хог хаягдал нь гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангаагүй, дагалдах бичигт үл зохицол үүссэн, тоо, хэмжээтэйгээ зөрж байвал уг хаягдлыг хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзах эрхтэй.
- 4.2.3 Үүсгэгч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр аюултай хог, хаягдлыг гэрээнд заасан буюу товлосон хугацаанаас 30-аас дээш хоногоор хүлээн авагчид шилжүүлэлгүй хоцроовол хүлээн авагч тал гэрээг нэг талын санаачлагаар цуцлах эрхтэй.
- 4.2.4 Аюултай хог хаягдал хүлээн авсан төлбөр тооцоог үүсгэгчээс гэрээнд заасан хугацааны дотор төлөхийг шаардах эрхтэй.
- 4.2.5 Аюултай хог хаягдлыг хүлээж авсан актыг үүсгэгчид гаргаж өгнө.
- 4.2.6 Хүлээн авагч аюултай хог хаягдлыг хүлээн авснаас хойших түүний хадгалалт, устгал, дахин боловсруулалтыг хариуцна.
- 4.2.7 Үүсгэгчээс Аюултай хог хаягдал шилжиж ирэх үед хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.

Тав. Аюултай хог хаягдлыг шилжүүлэх, шилжүүлэн авах

- 5.1. Үүсгэгч гэрээгээр тохиролцсон хугацаандаа аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг буюу Төв аймаг, Сэргэлэн сум, 1-р багийн нутаг дэвсгэрт орших “ЦЭЦҮҮХ ПЕ&ПП ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР”-т хүргэнэ.
- 5.2. Үүсгэгч гэрээнд заасан шилжүүлэх хугацаанаасаа өмнө аюултай хог хаягдлыг шилжүүлэх эрхтэй ба ингэх тохиолдолд Хүлээн авагчид энэ тухай 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдсэн байна.
- 5.3. Үүсгэгч аюултай хог хаягдлаа “Аюултай хог хаягдал” тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжийн тусгай зориулалтын, зохих тэмдэг тэмдэглэгээтэй тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлүүлэн Хүлээн авагчид хүргэж өгнө.
- 5.4. Талууд аюултай хог хаягдлыг хүлээлцэхдээ дагалдах бичиг болон гэрээнд заасан тоо, хэмжээтэй нийцэж байгаа эсэх, үл зохицол байгаа эсэхийг шалгах ба нийцэж байвал энэ тухай акт үйлдэж гарын үсэг зурж хүлээн авагч тал хүлээн авна.
- 5.5. Аюултай хог хаягдал нь гэрээний 4.2.2-т заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд хүлээн авагч хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзаж болно. Энэ тохиолдолд Аюултай хог хаягдлыг үүсгэгчид буцааж хүргэхтэй холбогдон гарах зардлыг үүсгэгч тал хариуцна.



Хуудсыг баталгаажуулсан:



Зургаа. Өмчлөх эрх шилжих


- 6.1. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид дагалдах бичгээр хүлээлгэн өгөх хүртэл хог хаягдлын өмчлөгч байна.
- 6.2. Үүсгэгч нь хог хаягдлыг хүлээн авагчид ачиж, тээвэрлэн хүлээн авах цэг дээр дагалдах бичгээр хүлээлгэн өгснөөр өмчлөх эрх хүлээн авагчид шилжсэн гэж үзнэ.
- 6.3. Аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг дээр хүлээн авагчид хүлээлгэн өгөх хүртэл түүний үр шим, эрсдэл үүсгэгчид байх ба хүлээн авагчид хүлээлгэн өгснөөр үр шим, эрсдэл хүлээн авагчид шилжинэ.

Долоо. Хариуцлага, маргаан шийдвэрлэх журам

- 7.1. Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн эсхүл үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас нөгөө талдаа учирсан аливаа хохирлыг холбогдох нотлох баримтад үндэслэн бүрэн хариуцаж нөхөн төлнө.
- 7.2. Үүсгэгч энэ гэрээний 3.8-д заасны дагуу үнийг төлөх хугацааг хэтрүүлсэн бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд Хүлээн авагчид төлнө.
- 7.3. Хэрэв Хүлээн авагч нь Үүсгэгчээс ирүүлсэн хог хаягдлыг энэ гэрээний 3.4-т заасан хугацааны дотор зохих журмын дагуу хүлээн аваагүй, хугацааг хожимдуулсан бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд гэрээгээр тохиролцсон үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд Үүсгэгчид төлнө.
- 7.4. Алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 10%-аас хэтрэхгүй байна.
- 7.5. Талууд гэрээнээс татгалзах болон цуцлах үндэслэлийг иргэний хуулиар зохицуулна.
- 7.6. Үүсгэгч тал аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлэхдээ дагалдах бичиг болон гэрээний хавсралт 1-д заасан тоо хэмжээ, химийн бодисын нэр хаягийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй бөгөөд буруу, зөрүүтэй худал мэдээлсэнээс болж гэрээний үнийн дүн өөрчлөгдөх, эсвэл үүнээс үүдэж хохирол учирвал хүлээн авагч хариуцахгүй болно.
- 7.7. Энэ гэрээтэй холбогдон Талуудын хооронд үүссэн аливаа санал зөрөлдөөн, маргаантай асуудлыг Талууд эв зүйгээр хэлэлцэн шийдвэрлэхийг чармайх бөгөөд ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

Найм. Давагдашгүй хүчин зүйл

- 8.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал гэдэгт үерт автах, гал түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэд өртөх, газар хөдлөх, зуд болох, тахал болон бусад байгалийн хүчин зүйлс мөн цэрэг дайны үйл ажиллагаа, төрийн эрх барих байгууллагын шийдвэр буюу экспорт, импортын хориг, ажил хаялт, үйлдвэрлэгчийн бүх төрлийн сул зогсолт зэрэг талуудын үйл ажиллагаанаас үл хамаарах үндэслэлээр энэхүү гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдлыг бий болгохыг ойлгоно.
- 8.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээ биелэгдэх боломжгүй тохиолдолд талууд бие биедээ нэн даруй мэдэгдэх ба гэрээний хугацаа дээрх нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар сунгагдах буюу тодорхой хугацаа зааж сунгаж болно.



Хуудсыг баталгаажуулсан:




- 8.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас бараа материал утсан, дутсан тохиолдолд шилжүүлэн хүлээлгэн өгөх хүртэлх эрсдэлийг үүсгэгч, шилжүүлэн хүлээн авснаас хойших эрсдэлийг хүлээн авагч хариуцна.
- 8.4. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлыг зохиомлоор буюу болгоомжгүйгээр бий болгосноос бусад тохиолдолд форс мажорын нөхцлөөс шалтгаалан учирсан хохирлыг хариуцах үүргээс талууд чөлөөлөгдөнө.

Ес. Бусад зүйл

- 9.1. Энэхүү гэрээний хэрэгжилтийн явцад гэрээнд аливаа нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд бичгээр үйлдэж эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 9.2. Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр оруулах ба талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 9.3. Энэхүү гэрээг Монгол хэл дээр хоёр хувь үйлдэж, Үүсгэгч тал 1 хувь, Хүлээн авагч тал 1 хувийг тус тус хадгалсан нь хуулийн ижил хүчинтэй.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Үүсгэгч талыг төлөөлж:
Майнинг Технологи Энд Экуйпмент
ХХК -ийн Оффис Менежер

 / Ц.Оюунчимэг/

Суурин утас: 7766 - 0151

Гар утас: 8801 - 7550

Регистер: 5213045

УБ гэрчилгээний дугаар: 000125861

Химийн бодис ашиглах, импортлох
тусгай зөвшөөрлийн дугаар: 0001182 /
0001405

Хаяг: Баянзүрх дүүрэг, 26-р хороо,
Нийслэл хүрээ өргөн чөлөө, “Парксайд
Центр” төв 3 давхарт, 305 тоот

Email хаяг: info@mte.mn

Хүлээн авагч талыг төлөөлж:
Цэцүүх Трейд ХХК-ийн
Үйлдвэрийн дарга

_____ / Б.Дарамбазар /

Нягтлан бодогч

 /Т.Буяндэлгэр/

Суурин утас: 70189778

Гар утас: 99057786


Регистер: 2066521

УБ гэрчилгээний дугаар: 9011026056


Тусгай зөвшөөрлийн дугаар: Б-000001

Хаяг: Баянгол дүүрэг, 5-р хороо,
Энхтайвны өргөн чөлөө – 64/2, Цэцүүх
Трейд ХХК-ийн оффис, үйлчилгээний байр

Email хаяг: Darambazar@tsetsuuh.mn



Хуудсыг баталгаажуулсан:




“Цэцүүх Трейд” ХХК, “Майнинг Технологи Энд Экуйпмент ХХК ” ХХК-ийн хооронд
байгуулсан Аюултай хог хаягдал шилжүүлэх
2022 оны 01 дугаар сарын 15 -ны өдрийн
Ш-22/ 01 тоот гэрээний Хавсралт № 01

2022-2023 онд Майнинг Технологи Энд Экуйпмент ХХК ХХК-ИЙ ЖИЛД УСТГУУЛАХ
АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН ХЭМЖЭЭ

№	Тухайн сав баглаа агуулагдаж бодисын мэдээлэл	Аюултай хог хаягдлын савны төрөл	Жилд үүсэх тоо хэмжээ / ш, кг, тонн /			
			1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
1	F13S Dust Control F13S powder AOS92	Химийн бодисын шуудай	50 кг	50 кг	100 кг	100 кг
2						

ҮҮСГЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:

Майнинг Технологи Энд Экуйпмент
ХХК -ийн Оффис Менежер


..... / Ц.Оюунчимэг/

Суурин утас: 7766 – 0151

Гар утас: 8801 - 7550

УБ гэрчилгээний дугаар : 000125861

Регистер: 5213045

Химийн бодис ашиглах, импортлох
тусгай зөвшөөрлийн дугаар: 0001182 /
0001405

Хаяг: Баянзүрх дүүрэг, 26-р хороо,
Нийслэл хүрээ өргөн чөлөө, “Парксайд
Центр” төв 3 давхарт, 305 тоот

Email хаяг: info@mte.mn

Шуудангийн хаяг :




ХҮЛЭЭН АВАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:

Хүлээн авагч талыг төлөөлж:
Цэцүүх Трейд ХХК-ийн
Үйлдвэрийн дарга

..... / Б.Дарамбазар /

Нягтлан бодогч


..... /Т.Буяндэлгэр/

Суурин утас: 70189778

Гар утас: 99057786

Регистер: 2066521

УБ гэрчилгээний дугаар: 9011026056

Тусгай зөвшөөрлийн дугаар: Б-000007

Хаяг: Баянгол дүүрэг, 5-р хороо,
Энхтайвны өргөн чөлөө – 64/2, Цэцүүх
Трейд ХХК-ийн оффис, үйлчилгээний байр

Email хаяг: Darambazar@tsetsuuh.mn

Шуудангийн хаяг: ШХ-1138

Хуудсыг баталгаажуулсан:









Хуудас 6/9

“Цэцүүх Трейд” ХХК, “Майнинг Технологи Энд Экуйпмент ХХК -ийн ” ХХК-ийн хооронд
байгуулсан Аюултай хог хаягдал шилжүүлэх
2022 оны 01 дугаар сарын 15 -ны өдрийн
Ш-22/01. тоот гэрээний Хавсралт № 02


**ХИМИЙН ХОРТОЙ БОДИС ХАДГАЛСАН ХАЯГДАЛ ХУВАНЦАР САВ
ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ТАРИФ**


(тээврийн зардал багтаагүй үнэ болно)

№	Үйлчилгээний төрөл	Хог хаягдлын төрлийн код	Зураг	Хэмжих нэгж	Нэгж үнэ төг
1	Химийн бодисын хаягдал хуванцар, сав, канистр 0,5л, 1л, 2,5л, 5л, 10л, 25л, 50л, 60л,	150109		1кг	1150
2	Химийн бодисоор бохирдсон тостой Цаасан болон кардонон сав баглаа боодол	150101		1кг	1150
3	Химийн хуванцар торх 100л	150109		1ш	4800
4	Химийн хуванцар торх 200л	150109		1ш	7900
5	Химийн хуванцар ИВС танк 1000л	150109		1ш	26000
6	Хортой бодисоор бохирдсон шингээгч, бохир алчуур материал, тусгайлан заагдаагүй хамгаалалтын хувцас	150201		1кг	1930
7	Полипропилен уут, шуудай, 25кг, 50 кг, 1 тн big bag шуудай/	150109		1кг	1380



Хуудсыг баталгаажуулсан:




					
8	Төмөр торх, сав 20л, 50л, 120л, 200л			1кг	900

Тайлбар. 1. Дээрх үнэнд химийн хортой бодис хадгалсан хаягдал хуванцар савыг хадгалах, дахин боловсруулах үйлчилгээний хөлс бөгөөд тээврийн зардал ороогүй болно.

2. Химийн хортой бодис хадгалсан хуванцар савыг хүлээн авагч авахдаа жинлэж авах ба бага хэмжээтэй тохиолдолд тн-ийг килограммд шилжүүлж тооцно.



Хуудсыг баталгаажуулсан:



Хуудас 8/9

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ХАЯГДЛЫН ДАГАЛДАХ БИЧИГ

№ 00362

Дагалдах бичгийн дугаар:

/шаардлагатай тохиолдолд нэмэлт хуудас хэрэглэнэ. /

1. Үүсгэгчийн талаарх мэдээлэл:

Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар: 001224

Аюултай хог хаягдал үүсгэгч байгууллагын нэр: Наймсал тэнгэр змг

Эхний шийт ХХК.

2. Аюултай хог хаягдлыг хүлээлгэн өгсөн:

Овог нэр

Албан тушаалтан

Гарын үсэг:

Огноо:

Ц. Сүхбатбаяр

С.Ф.Н.С. Мөнхтөр

2021 он 10 сар 06 өдөр

3. Тээвэрлэгчийн талаарх мэдээлэл:

1/ Тээврийн хэрэгслийн улсын дугаар: 60411 ЧБМ. Тээвэрлэгчийн бүртгэлийн дугаар:.....

4. Аюултай хог хаягдлын талаарх мэдээлэл:

	Аюултай хог хаягдлын нэр	Аюулын ангилалын зэрэглэл	Савлагааны бүлэг	Савны		Хэмжээ	Нэгж /кг Эсвэл/ш	Аюултай хог хаягдлын код
				дугаар	Төрөл			
1	13c тэнк	x	Бийтүү		УИРФ	10	ш	150109
2	1100/900(25)	x	Бийтүү			1500	ш	150109
3								
4								

3. Тээвэрлэх үед анхаарах нэмэлт зааварчилгаа, мэдээлэл:

5. Аюултай хог хаягдлыг хүлээн авсан тээвэрлэгч :

1. Овог нэр: Ц. Чингиз Гарын үсэг: Ц. Чингиз 2021 он 10 сар 06 өдөр

6. Үл зохицол:

7. Аюултай хог хаягдлыг хүлээн авагчийн талаарх мэдээлэл:

Аж ахуйн нэгжийн нэр: ЦЭЦҮҮХ ТРЕЙД ХХК

Цэцүүх трейд ХХК бүртгэлийн дугаар: Б-0000100125

Аюултай хог хаягдлыг хүлээн авсан:

Овог нэр : Цэцүүх трейд ХХК

Албан тушаал

Гарын үсэг/тамга /

Огноо

С. Доржиев

10/06



2021 он 10 сар 06 өдөр

ХОГ ТЭЭВЭРЛЭЛТИЙН ГЭРЭЭ

2022 оны 10 дугаар
Сарын 17-ны өдөр

№ 114

Ханбогд сум

Нэг.Нийтлэг үндэслэл

Нэг талаас “Ханбогд хот тохижилт”ОНӨААТҮГазар түүнийг төлөөлөн захирал Догь овогтой ЭРХЭМБААТАР /цаашид “Гүйцэтгэгч”гэх/ нөгөө талаас 3625486 регистрийн дугаартай “ ГОВЬ ГАЗ ” ХХК-нийг төлөөлж Захирал Цогт - Очир овогтой Баттөр /цаашид “Захиалагч” гэх/ нар Монгол улсын хог хаягдлын тухай хууль, үндэслэн харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

1.1. Энэхүү гэрээ нь хогийг ачиж, тээвэрлэх, уг үйлчилгээг зохицуулахад чиглэгдэнэ.

Хоёр. Гэрээний хугацаа

2.1. Гэрээний хугацаа 2022 оны 10 дугаар сарын 17 -ны өдрөөс эхлэн 2023 оны 10 дугаар сарын 16 - ны өдөр хүртэл 1 жил хүчинтэй.

Гурав. Захиалагчийн эрх үүрэг

Захиалагч дор дурдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

3.1. Хог тээвэрлэгч байгууллагын хог ачиж, тээвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих.

3.2. Төлбөрийг жилд 2 удаа хувааж төлнө.Гэрээ байгуулахад 6 сарын төлбөрийг урьдчилан төлсөнөөр гэрээ баталгаажна.

3.3.. Захиалагч нь хог хаягдалын ачилтыг хариуцах ба төлбөрийг төлсөнөөр гүйцэтгэгч хог хаягдалыг тээвэрлэнэ

3.4. Захиалагч нь хогийг ил задгай болон ухсан нүхэнд асгахгүй ба зориулалтын хуванцар сав,поошиг зэрэгт хийсэн байна.Хогийг ухсан нүхэнд хийхийг хориглоно.

3.5. Хууль тогтоомжинд заасан бусад эрх эдэлж,үүрэг хүлээнэ.

Дөрөв. Гүйцэтгэгчийн эрх үүрэг

Гүйцэтгэгч нь дор дурдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

4.1.Захиалагч байгууллагын хог хаягдлыг сард хоёр удаа тээвэрлэх;

4.2. Тээвэрлэсэн хог хаягдлыг төвлөрсөн цэгт тээвэрлэж, хогийн төвлөрсөн цэгийн дотоод журмыг чанд сахих;

4.3. Машин техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж, машин техник эвдэрсэн тохиолдолд хог ачиж цуглуулах хуваарийг алдагдуулахгүй байлгах зорилгоор сэлгэн ажиллуулах машин техникийн бэлэн байдлыг хангах;

4.4. “Хог хаягдлын талбайн хураамж болон үйлчилгээний төлбөрийн хэмжээ тогтоох тухай” тогтоолд заасан үнийн тарифаар үйлчлэх

4.5. Хууль тогтоомжинд заасан бусад эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Тав. Төлбөр тооцоо

- 5.1. Гүйцэтгэгч нь төлбөрийг захиалагчид нэхэмжлэл хүргүүлэх;
5.2. Захиалагч нь үйлчилгээний төлбөрийг 2 ачилт буулгалт хөлс болон шатахуун орсон үнэ 1 сарын 330 000 (Гурван зуун гучин мянга, НӨАТ орсон) төгрөг буюу 6 сарын төлбөр болох 1,980,000 төгрөгийг Төрийн банкны Ханбогд хот тохижилт ОНӨААТҮГ нэртэй 211000143144 тоот дансанд шилжүүлж байна.

Зургаа. Давагдашгүй хүчин зүйлс

- 6.1. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас Талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй эсхүл зохих ёсоор биелүүлээгүй, биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нөгөө талдаа ажлын 3 хоног дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.
- 6.2. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлийн 1 сараас дээш хугацаагаар хойшлогдоно.
- 6.3. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг, нийтийг хамарсан үймээн, эсэргүүцлийн хөдөлгөөн, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио цээр зэрэг талуудын хүсэл зорилгоос үл хамаарах нөхцөл байдлыг ойлгоно.


Долоо. Бусад

- 7.1. Энэхүү гэрээнд тусгагдаагүй бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.
- 7.2. Гэрээг 2 эх хувь үйлдэнэ.
- 7.3. Гэрээний хугацаа нөхцөл байдлын талаар өөрчлөлт оруулахаар бол хоёр тал 30 хоногийн өмнө урьдчилан мэдэгдэж, харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 7.4. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Гүйцэтгэгч төлөөлж:

“Ханбогд хот тохижилт”
ОНӨААТҮГ-ын захирал


... /Д. Эрхэмбаатар/
Утас: 88115997


Захиалагч төлөөлж:

“Говь Газ” ХХК-нийн
захирал


... /Ц. Баттөр/
Утас: 99130151



ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
МАЙНИНГ ТЕХНОЛОГИ ЭНД
ЭКУЙПМЕНТ ХХК-ИЙН ЕРӨНХИЙ
ЗАХИРАЛ



УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр

Дугаар 2022/06

Их булаг

Нэг. Ерөнхий нөхцөл

Энэхүү Ус ашиглах гэрээ /цаашид “Гэрээ” гэх/-г Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1-д заасны дагуу аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас гаргасан 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 22/030 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Ханбогд сумын Засаг даргын олгосон 2021 оны 10 сарын 05-ны өдрийн А/311 тоот ус ашиглах зөвшөөрлийг тус тус үндэслэн:

Нэг талаас Ус ашиглуулагч /цаашид “Ус ашиглуулагч” гэх /-ийг төлөөлж Ханбогд сумын ЗДТГ-ын Уул уурхай-Ус хариуцсан Байгаль хамгаалагч Онолбаатар овогтой Ангараг,

Нөгөө талаас Ус ашиглагч /цаашид “Ус ашиглагч” гэх /-ийг төлөөлж Өмнөговь аймаг, Ханбогд сум, Жавхлант 3-р баг, Оюутолгой төслийн зүүн талд байрлах агуулах хаягт орших “Майнинг технологи энд экуйпмент” ХХК (УБД:1111010073, РД:5213045) Менежер Ц.Оюунчимэг нар нь ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1 Ус ашиглах зориулалт:

-Унд, ахуй болон ногоон байгууламжаар зориулалтаар ашиглана.

2.2 Ашиглах усны хэмжээ:

2.2.1 Унд-ахуй: 602.5 м³/хон

2.2.2 үйлдвэрлэл м³/хоног

2.2.3 үйлчилгээ м³/хоног: ногоон байгууламж усалгаа- 2400 м³

2.2.4 эмчилгээ, сувилгаа, хүн/хоног

2.2.5 Нийт ашиглах усны хэмжээ: **3002.5 м³/жил**

2.3. Усны чанар найрлага: Унд ахуйн уснаас дээж авч, улирал тутам шинжилгээ хийлгэн хариу болон дүгнэлтийг БОАЖГазарт хүргүүлэх

2.4 Усны эх үүсвэрийн

Байршил	Ханбогд сумын Жавхлант баг, өөрийн эзэмшлийн
---------	--

Солбицол	1 худаг	42° 05 45.79 'N, 106° 90 48.03'E
Барилга байгууламж	1*1 хэмжээтэй тоосгоор хамгаалагдсан. 3м3 усны нөөцийн сав	
Тоног төхөөрөмжийн нэр, марк	DAFU-4SDH1100S	

2.5 Хаягдал усны: Унд ахуйн хэрэгцээнд ашигласан уснаас гарах хаягдал усны хэмжээ, чанар, найрлага, бохирдуулагч бодисын хэмжээ зэрэгт улирал тутам шинжилгээ хийлгэн хариу болон дүгнэлтийг БОАЖГазар-т ирүүлэх

Хаях цэгийн байршил:

Солбицол:

2.6 Хаягдал усны дахь бохирдуулах бодисын хэмжээ. Усны биохимийн шинжилгээний дүнг хавсаргана.

- ❖ Жинлэгдэх бодис, кг
- ❖ Органик бодис, кг
- ❖ Эрдэс бодис, кг
- ❖ Хүнд металл, кг
- ❖ Аюултай бохирдуулах бодис, гр

2.7 Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин:

2.8 Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал мян.төг	Хариуцагч
1	“Дэлхийн усны өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх	2023.03.22	150.0	ЗДТГ, МТЭЭ ХХК

2.9 Усны тоолуурын:

Төрөл, нэр, дугаар: SH-MECH

Загвар: LXSG DN208 Q3=4.0 м3/цаг S/N:202001384

Тоолуурын тоо: Стандартчилал, хэмжил зүйн газраар баталгаажсан 1 тоолууртай.

Суурилуулсан байгууллага огноо: 2021-09 №001217

Баталгаажуулсан байгууллага огноо: 2022.09.06

Тоолуурын заалт: 280 м3

2.10 Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:

Усны экологи эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 302 тогтоолоор Галба-Өөш, Долоодын говийн сав газарт тогтоосон газрын доорхи усны экологи эдийн засгийн суурь үнэлгээгээр, 2013 оны 326, 327 тогтоолоор ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр, хувь хэмжээгээр усны нөөц ашигласны төлбөрийг тогтоож тогтоосон хэмжээгээр “Төсвийн тухай хууль”-ийн 23.8.9 дахь заалт, Өмнөговь аймгийн ИТХ-ын хурлын 2022 оны 06 сарын 10-ны өдрийн 6/5 дугаар тогтоолын дагуу орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ.

1м³ усны нөөц ашигласны төлбөр 3996х15%х0,16=95.9 төг

- 3996 төг/м³- Галба-Өөш, долоодын говийн сав газарт газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ

0.16 – ашиг олох зориулалтаар унд, ахуйн ашигласан усны шоометр тутамд тооцох ашиглалтын зориулалтын итгэлцүүр
15%- ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуй нэгж байгууллага, иргэний ашигласан усны шоометр тутамд усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ

Унд ахуй: $602.2 \text{ м}^3/\text{жил} * 96 \text{ төг} = 57,840$ (тавин долоон мянга найман зуун дөчин төгрөг)
Ногоон байгууламж: $2400 \text{ м}^3/\text{жил} * 71.93 \text{ төг} = 172,632$ (нэг зуун далан хоёр мянга зургаан зуун гучин хоёр төгрөг)

Нийт төлбөр: 228,072 (хоёр зуун хорин найман мянга далан хоёр төгрөг)

Усны нөөц ашигласны төлбөрийг Усны тухай хуулийн 30.1.4-т заасны дагуу эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан усны тоолуур суурилуулж тоолуурын заалтаар тооцон сар бүрийн 25-ний дотор сумын Байгаль хамгаалагчаар тоолуурын баталгаажуулалт хийлгэж төлбөрийг сар бүр орон нутгийн төсөвт төлж барагдуулах

- ❖ Сар бүрийн 25-нд татварын нэгдсэн сайтаар орж, төлбөрийн даалгавар үүсгэж, нэхэмжлэхний дугаараар төлнө.

2.11 Хаягдал усан дахь нэгж бохирдуулах бодист ногдох төлбөрийн хэмжээ:

Гурав. Талуудын эрх, үүрэг

Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан дагуу эрх эдэлж, үүрэг хүлээнэ.


Дөрөв. Бусад

- 4.1 Гэрээ нь талуудын гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 4.2 Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 4.3 Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.
- 4.4 Талуудын тохиролцсоноор / хууль, Засгийн газрын тогтоол, журамд өөрчлөлт орсон тохиолдолд / гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.
- 4.5 Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.
 - 4.5.1 ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн.
 - 4.5.2 Аль нэг тал татан буугдсан бол.
- 4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ус ашиглуулагчийг төлөөлж:

Ханбогд сумын ЗДТГ-ын Уул уурхай-Ус хариуцсан Байгаль хамгаалагч



О.Ангараг

Хаяг: Ханбогд сумын ЗДТГазар 103 тоот

Харилцах утас: 88545444

И-мэйл хаяг: angaa_zdtg@yahoo.com

Ус ашиглагчийг төлөөлж:

“Майнинг технолони энд экуйпмент” ХХК-ийн Менежер




Ц.Оюунчимэг

Хаяг: УБ хот, БГД, 4-р хороо, Газар бизнес төв, 2 давхарт, 209 тоот

Харилцах утас: 7766-0151, 88017550

И-мэйл хаяг: info@mte.mn

СУНГАЛТ

Сунгалт хийсэн шийдвэр	Он, сар, өдөр	Гарын үсэг, тамга
<p>Ус ашиглуулах дүгнэлт № 22/030 Ус ашиглах зөвшөөрөл А/311 2022.10.03 Ус ашиглах гэрээ - 2022/06 2022.11.02</p>	2022.11.02	

Тайлбар:

Ус ашиглах эрхийн бичгийг Улсын усны мэдээллийн санд бүртгэнэ.

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

ЗАХИАЛГА №: МБ 2022/183


ДЭЭЖИЙН ТӨРӨЛ,
ТОО:

Ус, 1

ЗАХИАЛАГЧИЙН НЭР: MINING TECHNOLOGY EQUIPMENT LLC

ДЭЭЖИЙН ДУГААР: Ус
ЛАБОРАТОРИЙН ДУГААР: Л-588
ДЭЭЖИЙН ХЭМЖЭЭ, мл: 500

№	ҮЗҮҮЛЭЛТ	СТАНДАРТ АРГА	НЭГЖ	ЗӨВШӨӨРӨГДӨХ ДЭЭД ХЭМЖЭЭ MNS 0900:2018	ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН
1	Бактерийн ерөнхий тоо	MNS ISO 6222:1998	1 мл-д	100	5
2	Халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нянгийн тоо	MNS ISO 9308-1:1998	100 мл-д	илрэхгүй	илрээгүй
3	Колиформ гэдэсний бүлгийн нянгийн тоо	MNS ISO 9308-1:1998	100 мл-д	илрэхгүй	илрээгүй
4	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян	MNS ISO 19250:2017	25 мл-д	илрэхгүй	илрээгүй
5	Clostridium perfringens	MNS ISO 6461-2:1998	100 мл-д	илрэхгүй	илрээгүй

Чанарын менежер  Д.Пүрэвжаргал

Сорилтын үр дүн зонхон тухайн дэвжинд хамаарна.
Дээжлэлтийн талаарх асуудлыг манай лаборатори хариуцахгүй болно.

ДЭЭЖИЛСЭН ОГНОО: 2022.08.09

ДЭЭЖ БОЛОВСРУУЛАЛТ: хийгдээгүй

ШИНЖИЛГЭЭ ЭХЭЛСЭН ОГНОО: 2022.08.09

ХУУДАСНЫ ТОО: 1

ШИНЖИЛГЭЭ ДУУССАН ОГНОО: 2022.08.15

Хамтран ажилласан таньд талархлаа.